НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ
БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

№	Гэрээгээр хүлээсэн үүрэг	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хувь
1	2	3	4
1	3.1.Хууль, дүрэм, энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, шүүхийн маргаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг шүүхэд төлөөлж гарсан үр дүнг Нийслэлийн Засагдарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцна.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Тэнүүн-Огоо ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайланг танилцуулж зөвлөлийн гишүүдийн саналаар Тэнүүн-Огоо ХХК-тай хэлцэл хийх шийдвэр гарсан. Хэлцэл хийх шийдвэрийн дагуу Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргал тус компанитай хэлцэл хийж, Тэнүүн-Огоо ХХК-ийн хөрөнгийг хүлээн авах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах саналыг Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/06/923 тоот албан бичгээр хүргүүлсэн. Улмаар Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/543 дугаар захирамжаар 75377504176 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгэн авч Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн Тэнүүн-Огоо ХХК-д холбогдох Эрүүгийн хэргийн шүүх хуралд Нийслэлийг төлөөлж Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргал итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаа бөгөөд шүүх хурал 3 удаа хойшлогдож, 3 удаа урьдчилсан хэлэлцүүлэг хийгдсэн байна.	100
2	3.2.Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлийг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 05 дугаар сарын 15, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр тус тус www.ERP.ulaanbaatar.mn нийслэлийн дотоод удирдлагын системийн Хяналт шинжилгээ, үнэлгээ цэсээр 4 удаа тайлагнасан.	100
3	3.3.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.	Тус газар нь 2024 онд орон нутгийн төсвөөс 322,659.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3,792.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 272.4 сая төгрөг нийт 326,724.3 сая төгрөгийн төсөв батлагдсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 2024 оны 01-11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацааны гүйцэтгэлээр 4,581.9 сая төгрөг төвлөрч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 316.0 сая төгрөг, нийт 4,897.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 272.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 1-11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацааны гүйцэтгэлээр 4321.9 сая төгрөг, хүлээгдэж буй	100

		гүйцэтгэлээр 22.7 сая төгрөг нийт 344.6 сая төгрөг төвлөрүүлсэн. Дээрх эх үүсвэрүүдээс өглөг, авлага нэмж үүсгэлгүй байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгө, бараа материалыг бэлтгэн ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллалаа. Үүнд: Цалин хөлс, урамшууллын зардалд 4,094.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 491.6 сая төгрөг, тогтмол зардал болон бусад урсгал зардалд 2,237.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын болон өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд олгох тэтгэмжийн зардалд 127.5 сая төгрөг, нийтийн тээврийн үйл ажиллагааны санхүүжилт, нөхөн олговорт 313,874.0 сая төгрөг, нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд нийлүүлэгдсэн Yutong bus ZK6116HG загварын их багтаамжийн 600 автобус, угсраа 31 автобус, дунд багтаамжийн county маркийн 50 автобусны иж бүрэн даатгалын зардалд 1,834.4 сая төгрөг нийт тус тус зарцуулагдсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлан өглөг авлагын 2023 оны 12 дугаар сар, энэ оны 01-10 дугаар сарын мэдээг дараа сар бүрийн 02-ны өдрийн дотор 11 удаа гаргаж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн хянуулж ажилласан. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуй нэгж байгууллагуудын гэрээний торгуулийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулахаар 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 01/06/03-01/06/17 дугаартай бичгүүдийг аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлсэн. Ингэснээр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудаар хуримтлагдсан өр төлбөрөө төлөх график гаргуулан энэ онд 2023 оноос өмнөх гэрээний торгуулиас 8 аж ахуй нэгж байгууллагаар 261.0 сая төгрөгийг төлүүлж, үүнээс 1 аж ахуй нэгж байгууллага өр төлбөрөө бүрэн барагдуулсан. 2024 онд санхүүжилтийн гэрээний дүгнэлтээр 2.9 сая төгрөгийн торгууль тавигдсаныг тухайн сард нь төлүүлэн ажилласан.	
4	3.4.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.	Төрийн захиргааны албан хаагчийг шатлан дэвшүүлэх мерит зарчмаар Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч 1, Гомдол хариуцсан ахлах ажилтан 1, Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн 1, Хяналт, шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн 1, Төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтнээр 1 албан хаагчийг тус тус томилж, 2024 онд нийт 5 албан хаагчийг томилсон.	100
		1.Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтийн хүрээнд 2023 онд 35 ширхэг, 2024 онд 565 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй Yutong маркийн автобус, 31 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй угсраа автобусаар буюу нийт 631 автобусаар парк шинэчлэлт хийсэн. Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийсэнтэй холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 3 байгууллага 235 автобусаар 13 чиглэлд, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж байгууллага 365 автобусаар 14 чиглэлд, их	

5	3.5.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.	багтаамжийн угсраа 31 автобусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 2 байгууллага 3 чиглэлд үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан өдөрт үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1220 болгон нэмэгдүүлсэн. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, хүлээгдлийн хугацааг багасгах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар чиглэлийн дахин төлөвлөлтийг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 74 чиглэлийн замналыг шинээр нээсэн. Мөн хот орчмын 21 чиглэл, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндсэн 7 чиглэл, дунд оврын 10 чиглэлийг шинээр нээж, 42 чиглэлийн замнал хааж, 25 чиглэлийн замналд зогсоол нэмж, 6 чиглэлийн замналаас зогсоол хасаж, 23 чиглэлийн замналд зогсоолын нэршил өөрчилж, 31 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан. 2.Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах "Түр" зөвшөөрөл хүссэн иргэн аж ахуйн нэгж байгууллагын холбогдох материалыг "Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем" www.smartcar.mn-ээр хүлээн авч 2024 оны жилийн эцсийн тайлант хугацаанд нийт 6570 орчим тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 1530, С ангиллын 4840, СЕ ангиллын 200 тээврийн хэрэгсэлд тус тус олгосон. Төрийн Үйлчилгээний Цахим ТҮЦ машинаар Нийслэлийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох "ЕС" зөвшөөрөл нийт 15550 тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 7515, С ангиллын 7260, СЕ ангиллын 775 тээврийн хэрэгсэлд тус тус олгож, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. 3. Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар www.autobox.mn сайтад нэвтрэх эрхээ авсан авто засварын үйлчилгээ эрхэлдэг 405 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 86662 автотээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллээ оруулан бүртгэлжүүлж хяналт тавьж ажилласан. Төрийн үйлчилгээний цахим портал www.e-mongolia.mn,, Авто үйлчилгээний мэдээллийн сан www.autobox.mn веб сайтуудаар авто үйлчилгээний ангиллын гэрчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч ажиллаж байна. 4.Улаанбаатар хотын нийтийн тээврийн төлбөрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд Ай Си Ти групп ХК-иас 1100 их багтаамжийн автобусанд зорчигч тоолох систем суурилуулахаар төлөвлөснөөс 1009 их багтаамжийн автобусанд суурилуулсан. Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, ажилчдын автобусны 1 дүгээр эгнээний зөвшөөрөл зэрэг	

		үйлчилгээг “Smart car” аппликейшны тусламжтай олгодог болсон нь хэрэглэгчдэд цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлт гарах болсон. 5.Техникийн хяналтын үзлэгийн төлбөрийг “Qpay” төлбөр тооцооны системээр төлөх хувилбарын бэлтгэл ажлыг хангасан.	
6	3.6.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2024-2025 онд 9 дэд зорилтын хүрээнд 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан. Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжилтийг гарган 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01/0/1672 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2024 оны байдлаар нэгтгэн хүргүүлэхээр ажиллаж байна.	100
7	3.7.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас тус газрын холбогдох албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажиллаж байна. Тус газарт 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 3551 өргөдөл, гомдол ирүүлснээс 3492 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдалд хяналт тавьж ажилласан. Мөн нийт 4541 албан бичиг ирснээс Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 62 бичиг, байгууллагаар бүртгэгдсэн 409 албан бичиг, хариутай 481 албан бичиг , хариугүй 4060 албан бичиг хүлээн авч газрын дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, хүлээлгэн өгч хяналт тавьж ажилласнаас хугацаандаа шийдвэрлэгдсэн 4362, шийдвэрлэлтийн шатандаа 117, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 62, Зөрчил тооцогдсон 182 албан бичгийг, байгууллагын хэмжээнд ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн дүн 96,51%, Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 4,74-тай байна.	100
8	3.8.Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.	2024 оны байдлаар Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 21 удаа хуралдаж, тус газарт хамааралтай нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн 81 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн erp.ulaanbaatar.mn цахим системийн хяналт шинжилгээ үнэлгээ цэсээр тайлагнан ажилласан.	100
9	3.9.Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Дээрх гэрээний хавсралт болох “Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт 73 арга хэмжээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/01/1592 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	100
10	3.10.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор erp.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн дагуу нийслэлийн хэмжээнд хийгдэж буй газрын чиг үүрэгт хамаарах мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж, холбогдох байгууллагууд болон иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна. Нийтийн тээврийн бодлогын газрын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд нийт 183 удаагийн мэдээлэл байршуулж, 6 удаагийн хэвлэлийн	100

		бага хурал хийж олон нийтийн сүлжээ болон 12 удаагийн телевизийн мэдээгээр иргэдийг мэдээллээр хангасан. Үүнд: 2024 оны байдлаар чиглэлийн өөрчлөлт, шинээр нээсэн маршруттай холбоотой 93, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч, техникийн ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтын талаар 10, соён гэгээрүүлэх чиглэлээр 7 шторк, 14 постер, 9 видео, нийгмийн хариуцлагын хүрээнд албан хаагчдын дунд зохион байгуулсан хандивын аяны мэдээ 1, нийтийн тээврийн бахархал сэдвийн хүрээнд 4 видео, нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд шинээр нийлүүлэгдсэн 600 автобусыг үйлчилгээнд гаргасан талаарх 63, Нийслэлийн бодлого шийдвэр, хэрэгжилттэй холбоотой 18, нийт 183 мэдээ, мэдээллийг бэлтгэн байгууллагын албан ёсны цахим хуудас/ transport.ub.gov.mn/ болон олон нийтийн сүлжээнд байршуулж иргэдийг мэдээллээр ханган ажилласан. Мөн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын вэб хуудасны цэс хэсэгт "Шилэн данс", "Хууль тогтоомж", "Ил тод байдал" гэсэн цэсүүдийг тухай бүр шинэчилж тушаал шийдвэр, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө, сул орон тоо, утасны жагсаалт, ажлын байрны тодорхойлолт, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээ, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээллүүдийг байршуулаад байна.	
11	3.11.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу transport.ub.gov.mn тус байгууллагын цахим хуудаснаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд шууд хандах эрхтэй болсноор сар бүрийн 08-ны дотор 2024 оны байдлаар 171 мэдээ, мэдээллийг нийтэд ил тод мэдээллэж, сар бүр шинэчлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
12	3.12.Хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоол, 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоол, 2020 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" батлах тухай 218 дугаар тогтоол, 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим	"Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу: Бодлогын баримт бичгийн хүрээнд 2 зорилго, 11 зорилт, 63 арга хэмжээ тусган боловсруулж Нийтийн тээврийн газрын 7 хэлтэс, нэгжийн дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс Хяналтын дагалдах хуудсаар санал авч батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

	арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоол, 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоол, 2021 оны "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах" тухай 360 дугаар тогтоол, 2022 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 430 дугаар тогтоол, 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.		
13	3.13.Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангаж, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцна.	Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх ажлын хүрээнд шинээр хийхээр төлөвлөж буй сүүдрэвч болон үйлчилгээтэй дулаан танхим хосолсон зогсоолын 12 байгууламжийн байршлыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01/02/814, 13 байгууламжийн байршлыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/02/2706 дугаартай албан бичгээр тус тус Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд болон гүйцэтгэгч Тэгш Хүслийн Гэрэл ХХК-нд хүргүүлсэн.	100
14	3.14.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллана.	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Г.Батзоригийн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Дүүргийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдалд түүвэрчилсэн хяналт шалгалт явуулах ажлын удирдамж, Нийтийн тээврийн бодлогын газрын хяналт шалгалтын хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 18-наас 21-ний өдрүүдийн 09:00-18:00 цагийн хооронд Чингэлтэй дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Баянзүрх дүүрэг, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт хог тээврийн үйлчилгээнд ажиллаж буй жолооч болон тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгасан. Шалгалтад 21 аж ахуйн нэгж байгууллагын 256 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас 117 зөрчил илрүүлж, техникийн хяналтад ороогүй тээврийн хэрэгсэлтэй 4 аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тус бүр 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгууль оногдуулж, цаашид Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах /оношилгоонд хамрагдах/, жолоочийн бичиг баримтын бүрдлийг хангах /мэргэшсэн жолооч/, тээвэрлэлт гүйцэтгэх авто замын чиглэл, хугацаа	100

		агуулсан холбогдох зөвшөөрлийг авах /ЕС зөвшөөрөл/, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад үүрэг өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.	
Гүйцэтгэлийн дундаж хувь /100*14/			100

Хянасан: ***Төсвийн ерөнхийлөн захирагч***

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч ..... /Х.Нямбаатар/

(огноо) .....

Тайлагнасан: ***Төсвийн шууд захирагч***

Нийтийн тээврийн бодлогын газрын дарга ..... /Д.Отгонжаргал /

(огноо) 2024.12.05

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг үндэслэн "Нийтийн тээврийн газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлан"-нг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ. Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд бодлогын баримт бичгийн хүрээнд 2 зорилго, 9 зорилт, 72 арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Нийт 2 зорилго, 11 зорилт, 72 зорилт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 98.1% байна. Үүнээс 69 арга хэмжээ 100%, 2 арга хэмжээ 70%, 1 арга хэмжээ 30% байна.

Тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 97,7%-тай байгаа нь Монгол Улсын Засгийн газрын2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр "Үр дүнтэй" (зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан) үнэлгээтэй байна.

Хэрэгжилт 70 хувьтай буюу "Тодорхой үр дүн гарч эхэлсэн" 2 заалт байна. Үүнд:

- Дүүжин замын тээвэр, Метро, BRT төслийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд мэдээ, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. НХТ 419, Зам, тээврийн салбарт хамтран ажиллах санамж бичиг.
- Ачаа тээврийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, менежментийг сайжруулах ажлын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 102 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан Нийслэлийн Засаг даргаар батлуулна.

Хэрэгжилт 30 хувьтай буюу "Үр дүнгүй" дараах 1 заалт байна.

- Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Зорчигч тээврийн терминал байгуулах боломжит байршлыг судлан танилцуулна. НХТЖҮЧ-9.23.1, Алсын хараа 2050-9.3.22, НХТ-428, Зам, тээврийн салбарт хамтран ажиллах санамж бичиг 2.5.

ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Даргын зөвлөлийн хурлаас “Нийтийн тээврийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнтэй холбоотой өгсөн үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлж, хэрэгжилтэд явцын хяналт тавих;

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилт “Үр дүнгүй” буюу 30 хувьтай байгаа байгаа Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Зорчигч тээврийн терминал байгуулах боломжит байршлыг судлан танилцуулах заалтын хэрэгжилт 2023 онд Эдийн засаг хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж “Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах” тендерт Гео зураглал ХХК нь шалгарч, 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.

Иймд зорилт арга, хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийн тооцоололдоо 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

70 хувьтай буюу “Тодорхой үр дүн гарч эхэлсэн” дээрх 2 заалтыг эрчимжүүлж ажиллах талаар холбогдох хэлтсүүдэд чиглэл өгч, үүрэгжүүлэх.

2.3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчдад Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлж, эрчимжүүлж Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БЯМБАСҮРЭН

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
1. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
1	Арга хэмжээ №1.1. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт тус газрын хариуцахаар тусгагдсан заалтуудын хэрэгжилт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг нэгтгэх.	Нэгтгэсэн тайлангийн тоо	-	5	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэхээр батлагдсан дээд газраас батлагдсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын тогтоол-2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-8, Засгийн газрын албан даалгавар-2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол-4, Нийслэлийн Засаг даргын захирамж-1 буюу нийт 17 шийдвэрийн 21 заалтын хэрэгжилт, "Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд нийслэл хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилт, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд батлагдсан 2024 оны нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, "Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд тус газраас хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжийн дагуу хэлтэс нэгжүүдээс тайланг хүлээн авч нэгтгэн, Нийслэлийн	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Засаг даргын Тамгын газарт /erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын цахим систем/-ээр хугацаанд нь тухай бүрт хүргүүлж ажилласан.		
2	Арга хэмжээ №1.2. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт тус газрын хариуцахаар тусгагдсан заалтуудын хэрэгжилт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана.	Хүргүүлсэн тайлангийн тоо	-	10	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан нийт 79 арга хэмжээний хэрэгжилтийг 2024 онд нийт 19 удаа Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан.	2024.01.02-2024.12.15	100
3	Арга хэмжээ №1.3."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	Тарьсан модны тоо	10	10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.8 дахь заалт, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нийслэлийн иргэд чөлөөт цагаа эрүүл, ногоон орчинд зөв боловсон өнгөрүүлэх, ая тухтай амарч зугаалах орчныг бүрдүүлэх, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
					04-ний өдрийн 58 дугаар зарлигаар батлагдсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон хот-Иргэний оролцоо" 2024 оны хавар, намрын мод тарих, арчлах арга хэмжээний төлөвлөгөө, хуваарийн дагуу бүх нийтийн хаврын мод тарилтад нэгдэж, 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр, 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Баянгол цэцэрлэгт хүрээлэнд газрын албан хаагчид 198 ширхэг мод тарив.		
4	Арга хэмжээ №1.6. Хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай чиглэлээр гаргасан зөвлөмжийн тоо	-	1	Оффисын аюулгүй ажиллагааны зааварчилгаа бэлдэн байгууллагын өрөө тасалгаануудад байршуулж албан хаагчдыг мэдээллээр ханган ажилласан. Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх" үндэсний хэмжээний "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ" нэг сарын аяныг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд аянд нэгдэн ажилласан. Мөн "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг "ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮД ХААН Ч АЮУЛГҮЙ-Шалтаг бүү тооч" уриатайгаар 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд нэгдэн постер мэдээллийг бэлтгэн байгууллагын пэйж хуудсанд байршуулан, уг аянд нэгдэн, хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/01/3102 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн салбар, ногоон болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшинд хүргүүлэн ажиллаа.	2024.01.02-2024.12.15	100
5	Арга хэмжээ №1.7. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл,	Дээд газрын тогтоол, шийдвэрээс өөрийн	0	1	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр нэгтгэн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
	Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, дээд газрын тогтоол, шийдвэрээс өөрийн байгууллагад холбогдох бүх заалтыг хяналтад бүрэн авч, бүртгэл тэмдэглэл хөтөлж цахимаар болон цаасаар холбогдох албан тушаалтанд мэдээлж үүрэгжүүлж, хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.	байгууллагад холбогдох бүх заалтыг хяналтад бүрэн авч, бүртгэл тэмдэглэл хөтөлсөн баримт бичгийн тоо			/erp.ulaanbaatar.mn/-ийн захидал харилцааны дэд системээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.		
6	Арга хэмжээ №1.8. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай А/349 дүгээр захирамжийн хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнах.	Хүргүүлсэн тайлангийн тоо	0	1	Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай" А/349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/01/1531 дугаартай албан бичгээр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. "Нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай" А/349 дүгээр захирамжийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган 12 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна.	2024.01.02-2024.12.15	100
7	Арга хэмжээ №1.11. Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг	Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	100	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/01/1671 дугаартай албан бичгээр, 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/01/3148 дугаартай албан бичгээр Төрийн	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
	боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулна.				албаны Зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Нийтийн тээврийн салбарт ажиллаж буй албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр орлогод нийцсэн орон сууцаар хангах чиглэлээр 5 квот ирсэн. Үүнээс "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 2, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-т 2, Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт 1 квот олгосон. Тус газрын 1 квотыг сугалаа явуулж Техникийн хяналтын үзлэгийн инженер С.Анхбаяр сугалж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар руу холбогдох материалыг бүрдүүлж 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/01/512 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчийн цалинг 10 хувиар, төрийн үйлчилгээний ажиллагсдыг 20 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна. "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр" 2024-2025 онд 9 дэд зорилтын хүрээнд 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Дээрх хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллалаа. 1.Албан хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох зорилгоор 2.Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд газрын даргын 2024 оны Б/56 дугаар тушаалын дагуу 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл долоо хоног бүрийн ажлын 1 өдөр чөлөө олгож сурах нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байна.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
					3.Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059, 2022 оны А/844 дүгээр захирамжаар 7 хэлтэс, 1 төв, 1 тасагтай 350 орон тоотойгоор ажиллаж байгаад Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар тус газар нь 8 хэлтэстэй болж нэмэгдэж, 350 орон тоотойгоор ажиллахаар бүтэц орон тооны өөрчлөлт орж батлагдсаны дагуу газрын даргын 2024 оны А/59 дугаар тушаалын байгууллагын бүтэц, ажил мэргэжлийн жагсаалт шинэчлэн батлах тухай, Б/96 дугаар тушаалаар төрийн захиргааны 30 албан хаагчийг үргэлжлүүлэн, 108 албан хаагчийг чөлөөлж, томилов. 4.Газрын даргын 2024 оны А/27, А/39, А/69, А/73, А/87 дугаартай тушаалуудаар Герман, Голланд, Хятад, Тайвань зэрэг улсад мэдлэг боловсролоо дээшлүүлэх, гадаад орны туршлагыг судалж Монголд нутагшуулах талаарх сургалтад 5 албан хаагчийг хамруулсан. Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж байгаа бөгөөд газрын даргын 2024 оны Б/56 дугаар тушаалын дагуу 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл долоо хоног бүрийн ажлын 1 өдөр чөлөө олгож сурах нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байна. Байгууллагаас албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлж, чадавхжуулах чиглэлээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулж төрийн захиргааны албан хаагчдыг бүрэн хамруулсан. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сургалт, судалгааны төвөөс зохион байгуулсан 25 удаагийн сургалтад төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг бүрэн хамруулсан.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
					Тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн Дотоод ажил хариуцсан ажилтан Ц.Одмандах Мандах Их сургуулийн Санхүү магистрын ангийг 1,5 жилийн хугацаанд суралцаж төгссөн. 3.Төрийн захиргааны 6 албан хаагчийг шатлан дэвшүүлэх мерит зарчмаар Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгчээр Б.Бадамдоржийг, Бүртгэл техник, технологийн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгчээр Д.Баясгаланг, Захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөц хариуцсан, ахлах мэргэжилтнээр Б.Болорцэцэгийг, Хяналт, шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтнээр Б.Мандхайг, Зорчигч тээврийн хэлтсийн ахлах мэргэжилтнээр Х.Баасансүрэнг, Төрийн үйлчилгээний 1 албан хаагчийг гомдол хариуцсан ажилтнаар С.Билгүүнийг дэвшүүлэн ажиллуулж байна. 4.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгууллагын албан хаагчдын дунд спортын 5 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. 5.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдэлтийг тухай бүр хийж, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд албан хаагчдыг мэдээллийг бүрдүүлэн, тухай бүр шинэчлэн ажиллаж байна.		
8	Арга хэмжээ №1.12. 2024 оныг "Тохижилт-Бүтээн байгуулалтын жил " болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний	Хүргүүлсэн тайлангийн тоо	0	2	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар 2024 оныг "Тохижилт-Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус байгууллагын чиг үүргийн дагуу тусгагдсан 6 арга хэмжээний хэрэгжилтийн нэгдүгээр улирлын тайланг 2024 оны 04 дүгээр	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
	хэрэгжилтийг нэгтгэн, хүргүүлэх.				сарын 05-ны өдрийн 01/01/920 дугаартай албан бичгээр, 2024 оны эхний хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/01/1530 дугаартай албан бичгээр, 2024 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.		
2. “Дүрэм”-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: /А/536/							
9	Арга хэмжээ №2.1. Газрын нь хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллана. Дүрмийн 6.5	Хүргүүлсэн тайлангийн тоо	-	1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай тус газрын даргын байгуулах гэрээний төсөл, гэрээний хавсралт болох “Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу: Бодлогын баримт бичгийн хүрээнд 2 зорилго, 11 зорилт, 73 арга хэмжээ тусган боловсруулж Нийтийн тээврийн газрын 7 хэлтэс, нэгжийн дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс Хяналтын дагалдах хуудсаар санал авч батлуулсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, хэлтсийн даргаар баталгаажуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2024 оны хариуцлагын гэрээний хэрэгжилт, түүний хавсралт болох байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/01/1592 дугаартай албан бичгээр мөн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлаг 2024 оны 12	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
					дугаар сарын 06-ны өдрийн 01/01/3151 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн.		
10	Арга хэмжээ №2.2. Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд холбогдох хууль журмын дагуу ажилтнуудыг томилох чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулна. Дүрмийн 7.1.2	Тушаал шийдвэрийн тоо	-	150	2024 оны жилийн эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /А/145, хүний нөөцийн чиглэлээр /Б/246 тушаалыг холбогдох хууль, журам, дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059, 2022 оны А/844 дүгээр захирамжаар 7 хэлтэс, 1 төв, 1 тасагтай 350 орон тоотойгоор ажиллаж байгаад Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар 350 орон тоотойгоор батлагдсаны дагуу газрын даргын 2024 оны А/59 дугаар тушаалын байгууллагын бүтэц, ажил мэргэжлийн жагсаалт шинэчлэн батлах тухай, Б/96 дугаар тушаалаар төрийн захиргааны 30 албан хаагчийг үргэлжлүүлэн, 108 албан хаагчийг чөлөөлж, томилсон. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/1403 дугаартай захирамжаар Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 1 дэх хэсэгт заасан “Нийтийн тээврийн бодлогын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжид “9.Хуулийн хэлтэс” гэж нэмснээр 9 хэлтэс, 350 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Бүтэц орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны шинээр 5, хүчингүй болгох 2, шинэчлэн батлуулах 23, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авах шатанд, төрийн	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
					үйлчилгээний 68 ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулсан.		
11	Арга хэмжээ №2.3. Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, дүрэм, журам баталж мөрдүүлнэ. Дүрмийн 7.1.1	Тушаал шийдвэрийн тоо	-	150	2024 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр /А/145 хүний нөөцийн чиглэлээр /Б/ 246 тушаалыг холбогдох хууль, журам, дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.	2024.01.02-2024.12.15	100
12	Арга хэмжээ №2.4. Хэлтэс /нэгж/-ийн дарга, төрийн захиргааны албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Дүрмийн 7.1.3	Хөдөлмөрийн гэрээ байгуулсан албан хаагчийн тоо	-	100	2024 оны жилийн эцсийн байдлаар 7 хэлтэс, төрийн захиргааны 29 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний 130 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024.01.02-2024.12.15	100
13	Арга хэмжээ №2.5. Сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо	-	2	Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн төр, захиргааны байгууллагын ажлын цагийн хуваарь зохицуулалт хийх тухай" А/630 дугаар захирамжийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд ажлын цаг 07:00-16:00 цаг, 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 08:00-17:00 цаг байхаар тогтоосны дагуу байгууллагын албан хаагчдад танилцуулж, "ERP" цахим системд ажлын цагийн өөрчлөлт оруулан цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
	байгуулна. Дүрмийн 7.1.4				хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангуулах талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Тус газрын даргын шийдвэрээр төрийн захиргааны албан хаагчдад болон Хяналт шалгалтын хэлтсийн удирдлага, автотээврийн хяналтын улсын байцаагч нарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг нэг бүрчлэн хүргүүлж судлуулав. 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр тус газрын хуулийн ахлах зөвлөх Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Зөрчлийн тухай хууль ба авто тээврийн улсын байцаагчийн хянан шалгах зөрчил, Автотээврийн улсын байцаагчийн хуулиар харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа, Монгол Улсын Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг хуулиудын үзэл баримтлал онцлогийн талаар сургалт зохион байгуулсан.		
14	Арга хэмжээ №2.6. Ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль, тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна. Дүрмийн 7.1.5	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	0	1	Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагчийг хамруулж, газрын даргын 2024 оны Б/56 дугаар тушаалын дагуу 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл долоо хоног бүрийн ажлын 1 өдөр чөлөө олгож сурах нөхцөлийг бүрдүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс зохион байгуулагдах сургалтад төлөвлөгөөний дагуу 50 албан хаагч, Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III", Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол хэлний тухай	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
					хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Архивын газар Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр "Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх" сэдэвт сургалтад 10 албан хаагчийг хамруулсан байна. Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж Удирдлагын академийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/387 тоот тушаалаар Е1555 сертификатыг аваад байна.		
15	Арга хэмжээ №2.7. Газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авах; Дүрмийн 7.1.6	Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтын тоо	-	Төрийн захиргааны-23 албан тушаалын тодорхойлолт, Төрийн үйлчилгээний 64 ажлын байрны тодорхойлолт батлуулах.	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар бүтэц орон тоо шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны шинээр-5, хүчингүй болгох 2, шинэчлэн батлуулах-23, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авах шатанд, төрийн үйлчилгээний 68 ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах шатандаа байна.	2024.01.02-2024.12.15	100
16	Арга хэмжээ №2.8. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Дүрмийн 7.1.10	Хүргүүлсэн саналын тоо	0	1	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлын хүрээнд Архивын Ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн "Архивын баримт нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай А/91 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн Нийтийн тээврийн газрын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр хурлаар хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлуулав.	2024.01.02-2024.12.15	100
17	Арга хэмжээ №2.9. Холбогдох хууль	Тушаалын тоо	0	15	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 81 дүгээр захирамжаар бүтэц орон тоо шинэчлэгдэн	2024.01.02-2024.12.15	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
	тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, батлагдсан төсөвт багтаан ажилтнуудын цалингийн шатлал, шагнал урамшууллын хэмжээг тогтоох				батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2024 оны 84, 128 дугаар тогтоолын дагуу газрын даргын 2024 оны Б/111 дүгээр тушаалаар байгууллагын нийт албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд өөрчлөлт оруулсан. Нийтийн тээврийн бодлогын газар байгуулагдсаны 55 жилийн ойг угтаж Автотээврийн салбарт идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, ажил хөдөлмөрөөрөө тэргүүлж, хамт олноо манлайлан ажилласан нэр бүхий албан хаагчдыг дараах шагналуудад нэр дэвшүүлэн дээд газар холбогдох материалуудыг хүргүүлсэн. Үүнд: 1."Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-оор 2; 2."Цэргийн гавьяаны одон"-оор 2; 3."Алтан гадас одон"-оор 9; 4."Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар 12; 5.Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр 4; 6.Сангийн яамны "Санхүү, банкны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр 3; 7.Зам, тээврийн хөгжлийн яамны "Жуух бичиг"-ээр 7, "Автотээврийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр 4, "Онц тээвэрчин" хүндэт тэмдгээр 4; 8.Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбооны "Манлай тээвэрчин" цол тэмдгээр 1; 9.Тээврийн Цагдаагийн албаны "Осолгүй манлай жолооч" тэмдгээр 1 албан хаагчийг шагнуулахаар холбогдох байгууллагуудад материалыг хүргүүлэн, эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, ажил хөдөлмөрөөрөө тэргүүлж, хамт олноо манлайлан ажилласан 23 албан хаагчийг "Төрийн дээд одон медаль"-иар, 28 албан хаагчийг салбарын болон Нийслэл, харьяа газрын шагналаар нийт 51 албан хаагчийг шагнасан байна.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэл-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
					баталсан "Нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалт зохион байгуулах ажлын удирдамж", Хан-Уул дүүргийн засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн "Авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хамтарсан хяналт, шалгалт хийх тухай" А/671 дүгээр захирамжийн хүрээнд Хан-Уул дүүргүүдийн нутаг дэвсгэрт авто засвар, авто угаалга ажиллуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Авто үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага MNS 5025:2020 улсын стандарт, Авто засвар, угаалгын үйлчилгээ эрхлэгч нь ангиллын гэрчилгээ авсан эсэх, ажлын байрны стандарт шаардлага хангаж байгаа, техникийн аюулгүй ажиллагаа ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар журам мөрдөж байгаа эсэхэд 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд автотээврийн хяналтын улсын байцаагч нар батлагдсан хуваарийн дагуу тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн И.Хулан, Ус сувгийн удирдах газрын Хяналтын инженер Т.Билгүүн, Нийтийн тээврийн бодлогын газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч Ж.Бум-Эрдэнэ, Ачаа тээвэр, логистикийн хэлтсийн Авто үйлчилгээ хариуцсан ажилтан Э.Энхням, Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн Т.Буянбат, Ц.Уянга, Байгаль орчны газрын улсын байцаагч Ц.Дагиймаа, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн улсын байцаагч Д.Байгалмаа, БТТХТасгийн дарга Э.Насанбат, ХУД-ийн цагдаагийн газрын хэлтэс 1-р хэсгийн цагдаагийн ахлах ахлагч Э.Одончимэг, 2-р, хэсгийн байцаагч дэслэгч Б.Отгонтөгс, М.Мөнх-Эрдэнэ, ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн улсын байцаагч М.Жамцдорж нарын хамт авто засварын үйлчилгээ эрхлэгч 96 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шалгалт хийж. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн авто үйлчилгээ ажиллуулахдаа эрх бүхий байгууллагаар ангилаллаа тогтоолгоогүй 8 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
					13 дахь зааltын дагуу 1 аж ахуйн нэгж байгууллагад 500.000 төгрөгийн, 7 иргэнд 350.000 төгрөгийн торгууль оногдуулж ажиллаа.		
13	4.6.Нийслэлийн нутаг дэвсгэрт автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын байцаагч нарыг хуваарилан ажиллуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр мэдэгдэл, албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;	Албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангасан хувь	87 %	90 %	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа их болон дунд багтаамжийн /угсраа/ автобусуудад Автотээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020, "Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5012:2021 улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг хангуулах, автотээврийн хэрэгслийн өнгө үзэмж, угаалга цэвэрлэгээ, техникийн бүрэн бүтэн байдал, чиглэлийн хаяг, "Нийтийн тээврийн үйлчилгээний талаар иргэдээс мэдээлэл авах зураг хуудас"-ыг батлагдсан хэмжээ, өнгө, загварын дагуу хийлгэж ажилласан. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг 19 аж ахуйн нэгж байгууллагын 1751 тээврийн хэрэгсэл шалгаснаас 281 зөрчил илэрч, 232 зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 19 аж ахуйн нэгж байгууллагад 28 албан шаардлага Автотээврийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч, 19 аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, албан шаардлагын биелэлт хангаагүй 4 аж ахуйн нэгж байгууллагад зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу 2.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаа.	2024.01.01 - 2024.12.31	100
14	4.7.Авто тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын тайлан, улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн тээвэрлэлтийн болон бусад төрлийн гэрээг цуцлах, гэрээний хариуцлага /анз/ хүлээлгэх, хугацаатай үүрэг даалгавар	Саналын тоо	-	1	Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарь мөрдөлт, баримт бичгийн бүрдэл, гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад хяналт тавин ажиллаа. Зөрчлийг арилгуулах зорилгоор 25 аж ахуйн нэгж байгууллагуудад 60 заалт бүхий 28 албан шаардлага хүргүүлж, албан шаардлагын биелэлт хангаагүй 4 аж ахуйн нэгж байгууллагад зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу 2.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулсан байна.	2024.01.01 - 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
	хүргүүлэх чиглэлээр санал танилцуулах;				Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтийг сар бүр дүгнэхэд зөрчлийн мэдээг нэгтгэн оноо хасах аргачлалаар гэрээний хариуцлага хүлээлгэн ажиллаж байна.		
15	4.8.Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн болон төрийн хяналт шалгалтын бусад байгууллагатай хамтран ажиллах;	Хамтран хийгдэх хяналт шалгалтын тоо	-	2	Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн алба, Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрууд хамтран 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг дуустал хуваарийн дагуу нийт 19 удаагийн сургалтыг зохион байгуулав. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудтай 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хурал зохион байгуулж тухайн байгууллагаас сургалтад хамрагдах жолооч нарын тоо болон сургалтыг зохион байгуулах өдрийн санал авч хуваарийг боловсруулж газрын даргаар батлуулсан. Сургалтыг удирдамжийн дагуу дараах сэдвээр зохион байгуулав. 1. Тээврийн цагдаагийн албаны Зам, тээврийн хяналтын хэлтсийн чиглэлийн ахлах зохицуулагч цагдаагийн дэд хурандаа Б.Батгэрэл "Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал" сэдвээр 2. Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч О.Гарьд, ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч У.Энхсоёмбо, ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч М.Содномбаяр, ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Батбаяр, ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Баяраа, ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Тэлмэн нар "Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт" сэдвээр 3. Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Х.Мөнх-Эрдэнэ	2024.01.01 - 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
					"Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Замын хөдөлгөөний дүрэм" сэдвээр 4. "Цагаан шонхорын жигүүр" НҮТББ / Нийт 5 удаа сургалт орсон./ "Жолоочийн харилцаа хандлага, үйлчилгээний соёл" сэдвээр 5. Нийтийн тээврийн бодлогын газрын Зорчигч, тээврийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Бадамханд, Хяналт шалгалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Мягмардорж "Нийтийн тээврийн салбарт мөрдөгддөг үндсэн стандартууд, жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил" сэдвээр тус тус сургалтыг удирдан явуулсан.		
16	4.9.Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэх, нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Зохион байгуулсан сургалтын тоо	-	5	Нийтийн тээврийн үилчилгээнд ажилладаг хувь хүний хариуцлага, ухамсар, ёс суртахууны төлөвшил, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг таниулах, хуулийг сахин биелүүлэх дадал бий болгох чиглэлээр дор дурдагдсан ажлуудыг зохион байгуулж ажиллаа. 1. Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн алба, Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрууд хамтран 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг дууусталх хугацаанд хуваарийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн 45 ажилтан, 1315 жолооч, нийтийн тээврийн таксийн үйлчилгээ эрхлэгч 4 аж ахуйн нэгжийн 36 жолооч, 5 шалгах механик нийт 1401 хүнийг хамруулан 24 удаагийн сургалтыг зохион байгуулав. Сургалтыг удирдамжийн дагуу дараах сэдвүүдээр хийсэн. а/ Тээврийн цагдаагийн албаны Зам, тээврийн хяналтын хэлтсийн чиглэлийн ахлах зохицуулагч цагдаагийн дэд хурандаа Б.Батгэрэл "Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал" сэдвээр;	2024.01.01 - 2024.12.31	90

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
					б/ Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч О.Гарьд, ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч У.Энхсоёмбо, ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч М.Содномбаяр, ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Батбаяр, ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Баяраа, ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Тэлмэн нар "Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт" сэдвээр; в/ Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Х.Мөнх-Эрдэнэ "Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Замын хөдөлгөөний дүрэм" сэдвээр; г/ "Цагаан шонхорын жигүүр" НҮТББ / Нийт 5 удаа сургалт орсон./ "Жолоочийн харилцаа хандлага, үйлчилгээний соёл" сэдвээр; д/ Нийтийн тээврийн бодлогын газрын Зорчигч, тээврийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Бадамханд, Хяналт шалгалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Мягмардорж "Нийтийн тээврийн салбарт мөрдөгддөг үндсэн стандартууд, жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил" сэдвээр тус тус сургалтыг удирдан явуулсан.		
17	4.10.Нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих иргэдийн төлбөр төлөх байдалд шалгалт явуулж, хуульд заасны дагуу шаардлага тавих, хөлс төлөөгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, шалгагч нарыг гудамж замд хуваарилан ажиллуулах;	Хийгдсэн шалгалтын тоо	-	2	Нийслэлийн нийтийн тээврийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр баталсан "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч болон шалгагч нар хамтран 2024 онд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс өссөн дүн, давхардсан тоогоор нийт 5200 чиглэлийн их болон дунд багтаамжийн 56,658 тээврийн хэрэгсэл, 113,989 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 327,010 зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, 117,237 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, Easy pay	2024.01.01 - 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
					/изи пей/ посын цэнэглэлтээр 1,778,718,700 мянган төгрөгийн цэнэглэлт хийн ажиллаж байна.		
18	4.11.Аюултай болон тусгай ачаа тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тээвэрлэгч ёж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх.	Хяналт шалгалтын тоо	-	1	Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, Ус сувгийн удирдах газрын дарга Т.Вандандорж нарын батлалсан "Бохир ус тээвэрлэн нийлүүлэх цэгүүдэд хяналт шалгалт хийх ажлын удирдамж"-ийн хүрээнд Баянзүрх дүүрэг, Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг бохир ус тээвэрлэн нийлүүлэх үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015, улсын стандарт, Аюултай ачаа. Ангилал тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS 4978:2017 улсын стандартуудын шаардлага хангаж байгаа, техникийн аюулгүй ажиллагаа ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар журам мөрдөж байгаа эсэхэд автотээврийн хяналтын улсын байцаагч, УСУГ-ын инженер нар 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж ажиллаа. Шалгалтаар 28 тээврийн хэрэгслийг хамруулж илэрсэн зөрчилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь арилгуулах боломжтой зөрчлүүдийг арилгуулж, 4 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйл 9 дэх хэсэгт зааснаар 3 иргэнд 75,000 төгрөг, 1 аж ахуйн нэгж байгууллагад 250,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож ажилласан.	2024.01.01 - 2024.12.31	100
19	4.12.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах, орчин үеийн цахим техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж ашиглах зэргээр ажлын бүтээмжийг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Хийгдсэн ажлын тоо	-	1	Нийслэлийн Нийтийн тээврийн газрын хуулийн зөвлөх Галсанжамц, ХШХ-ийн дарга Ц.Мягмар нар ЦЕГ-ын Мэдээлэл, технологийн төвийн дарга х/а н.Идэрцог, Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга д/х н.Мөнхзул нартай 2023 оны 09 дүгээр сард уулзаж Замын цагдаагийн албан хаагч нар ашиглаж байгаа Police reader-тэй ижил үйл ажиллагаатай төхөөрөмжийг тус газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч нар шугам замын хяналт шалгалтад ашиглаж зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжийн талаар санал солилцсон. Уг уулзалтаар "АТХУБ нарыг Torguuli.police gov.mn системд	2024.01.01 - 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
					холбоход манай зүгээс боломжтой харин програм хөгжүүлэх, системд ажиллах хүний цалин хөлс гэсэн санхүүгийн зардлыг аль тал шийдвэрлэх тал дээр хүндрэлтэй байх талаар цагдаагийн байгууллагаас зөвлөмж өгсөн. Автотээврийн хяналтын улсын байцаагч нарт энгэрийн камер, зөөврийн хэвлэх төхөөрөмж зэрэг бүрэн хэрэглэдхүүнээр хангах хүсэлтийг засан даргад танилцуулж 2025 оны төсөвт тусгуулсан байна. 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Нийтийн тээврийн удирдлагын дэд системийн хяналтын камерыг үйл ажиллагаанд нэвтрүүлж 19 аж ахуйн нэгж, байгууллагын 1004 тээврийн хэрэгсэлд хяналтын камерын бүрэн суурилуулж нийтийн тээврийн үйлчилгээг камераар хянах нөхцөл бүрдээд байна.		
20	4.14.Нийтийн тээврийн автобус, тролейбус чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээнээс бусад эгнээгээр зорчуулахгүй байх, чиглэлийн тээврийн хэрэгслийн буудалд зөв байрлуулах, иргэдэд чирэгдэлгүй, соёлтой үйлчлэх чиглэлээр хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, илэрсэн зөрчилд хуульд заасан шийтгэл оногдуулах;	Илрүүлсэн зөрчлийн тоо	-	-	Энхтайваны өргөн чөлөөний дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавих шалгалтын хүрээнд Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээг чөлөөлөх, автобусны зогсоолд зорчигчдын буух, суух нөхцөлийг хангуулах, түр болон удаан хугацаагаар зогссон суудлын автомашины зөрчлийг арилгуулахаар хөдөлгөөнт болон суурин 26 байршилд Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгалч нар нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт шалгалт хийж ажилласан. 2024 оны байдлаар Энхтайваны өргөн чөлөөний "Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ"-нд ажиллахдаа автобусны буудлын "Зогсоолын талбай"-д хориглосон цагаар зогссон 13582 автомашины зөрчлийг фото зургаар баримтжуулан "E-Police application"-ээр Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү шилжүүлж, 8811 зөрчил баталгаажиж эзэмшигчийн гэрийн хаягаар илгээн, нийт 176,220,000 төгрөгийн торгууль оногдуулсан.	2024.01.01 - 2024.12.31	90
21	4.16.Нийслэлийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх тоон мэдээллийг хөтөлж, цахим сангийн баяжилтыг хийх, энэ чиглэлээр дээд шатны	Мэдээллийн сангийн тоон мэдээллээр	-	100%	2024 онд "Зөрчлийн тухай хууль", "Төрийн хяналт шалгалтын тухай", "Автотээврийн тухай" хуулиуд болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба түүнд тавигдах шаардлага" MNS 5012:2021, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020,	2024.01.01 - 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
	байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах;				"Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013, холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор мөн тус газрын даргын баталсан тушаал шийдвэр хэрхэн биелэгдэж байгаад автотээврийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, 809 зөрчилд Зөрчлийн тухай хуулийг үндэслэн арга хэмжээ авч ажилласан зөрчлийн хэрэг материалын сүүлийн 6 жилийн бүртгэл хөтөлж, дэлгэрэнгүй мэдээллийн сан үүсгэн Нийслэлийн прокурорын газарт хянуулж ажилласан.		
22	4.17.Хэлтсийн чиг үүргийн хүрээнд хийгдэж буй ажлын талаар холбогдох мэдээ, мэдээллийг боловсруулж иргэдэд мэдээлэх, удирдлагыг мэдээллээр хангах;	Холбогдох мэдээллийн тоо	-	2	"Нийтийн тээвэр-Public transport UB" аппликейшн, байгууллагын веб-сайт, АТХУБ нарын групп болон facebook, Авто радио FM 96.3 шууд нэвтрүүлэг, нийт 12 удаа нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчигчдын цахим картаар тээвэрлэлтийн хөлс төлөлтөд хийж байгаа хяналт, шалгалт болон цахим картаар хөлс төлж зорчихын ач холбогдол, ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа жолооч нарт "Ачааны автомашины ЕС зөвшөөрөл" болон түр зөвшөөрөл авч нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд оролцох талаар олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийж ажилласан.	2024.01.01 - 2024.12.31	100
23	4.18.Хэлтсийн хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, албан хаагч, ажилтны ажлын цаг ашиглалтад хяналт тавих;	Тухай бүр	-	4	Нийтийн тээврийн газрын Хяналт, шалгалтын хэлтэс 2024 онд байдлаар хэлтсийн дарга-1, ахлах мэргэжилтэн-1, Автотээврийн хяналтын улсын байцаагч-11, ахлах менежер-1, Гомдол хариуцсан ахлах ажилтан-1, автотээврийн хяналтын ажилтан-3, Санал гомдол хариуцсан ажилтан-7, бүртгэл, судалгаа тайлан хариуцсан ажилтан-2, ахлах шалгагч-6, шалгагч-52, жолооч-5 нийт- 90 хүний орон тоотойгоор ажиллалаа. Албан хаагч нарын ажлын цаг ашиглалтад шугам замд хяналт тавьж, ажилчдын хавар, намрын хувцасны хангалтыг бүрдүүлж байна.	2024.01.01 - 2024.12.31	90
24	4.20.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын жолооч нарын дунд Уран жолоодлого-2024 тэмцээнийг зохион байгуулна.	Зохион байгуулсан тэмцээний тоо	-	1	Нийтийн тээврийн бодлогын газар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран их багтаамжтай автобусны жолооч нарын дунд жолооч нарын харилцаа хандлагыг төлөвшүүлж мэдлэг ур чадварыг нэмэгдүүлж, олон нийтэд сурталчлах зорилгоор УРАН ЖОЛООДЛОГО 2024	2024.01.01 - 2024.12.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
1	2	4	5	6	7		8
					тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Уран жолоодлого-2024 тэмцээнд 16 багийн 80 орчим тамирчид ур чадвар, авхаалж самбаагаа уралдуулснаас нэгдүгээр байранд Сутайн буянт ХХК, хоёрдугаар байранд Эрдэмтранс ХХК, гуравдугаар байранд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ыг баг тамирчид тус тус байр эзэлж, амжилт гаргасан.		
	Дундаж оноо					**93 оноо**	

ТАЙЛАН ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

Б.Мандхай /Б.МАНДХАЙ/
(Нэр, гарын үсэг)

2024 12 05
(Огноо)

-----o0o-----

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МАНДХАЙН
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Нийтийн тээврийн бодлогын газар

Нэгжийн нэр: Хяналт, шалгалтын хэлтэс

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ." НЗДҮАХ-6.3.15"					
1.	**Арга хэмжээ 1.1** Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид санал хүргүүлнэ. НХТ-418, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2	60	8	68	68
Зорилт 2. "Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. 3.3, 5.2, 5.4.1,"					
2.	**Арга хэмжээ 2.1.** Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана. /5.4.1./	60	8	68	68
3. "Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:					
3	**Арга хэмжээ 3.1.** 2024 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	60	8	68	68
4	**Арга хэмжээ 3.2.** "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	60	8	68	68
5	**Арга хэмжээ 3.3.** Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлд хяналт шалгалтаар гарсан дүн, мэдээллийг удирдлагад өгч ажиллана.	60	8	68	68

6	Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй тээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно. Дүрмийн 4.1.17	60	7	67	67
Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд					
7	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна.	60	7	67	67
8	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	60	7	67	67
Зорилт 4. "Дүрэм"-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: /А/536/					
9	4.1.Нийслэлийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын шаардлагад хяналт тавих, энэ чиглэлээр тээвэрлэгч аж ахуй нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн хувьд зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах;	60	7	67	67
10	4.2.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	60	7	67	67
11	4.3.Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	60	7	67	67
12	4.4.Хүүхдийн болон ажилчдын автобусны үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	60	7	67	67
13	4.5.Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	55	7	62	62
14	4.6.Нийслэлийн нутаг дэвсгэрт автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын байцаагч нарыг хуваарилан ажиллуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр мэдэгдэл, албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;	50	7	57	57
15	4.7.Авто тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын тайлан, улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн тээвэрлэлтийн болон бусад төрлийн гэрээг цуцлах, гэрээний хариуцлага /анз/ хүлээлгэх, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх чиглэлээр санал танилцуулах;	50	7	57	57

16	4.8.Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн болон төрийн хяналт шалгалтын бусад байгууллагатай хамтран ажиллах;	50	7	57	57
17	4.9.Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэх, нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	50	7	57	57
18	4.10.Нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих иргэдийн төлбөр төлөх байдалд шалгалт явуулж, хуульд заасны дагуу шаардлага тавих, хөлс төлөөгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, шалгагч нарыг гудамж замд хуваарилан ажиллуулах;	50	7	57	57
19	4.11.Аюултай болон тусгай ачаа тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх.	50	7	57	57
20	4.12.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах, орчин үеийн цахим техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж ашиглах зэргээр ажлын бүтээмжийг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	50	7	57	57
21	4.14.Нийтийн тээврийн автобус, тролейбус чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээнээс бусад эгнээгээр зорчуулахгүй байх, чиглэлийн тээврийн хэрэгслийн буудалд зөв байрлуулах, иргэдэд чирэгдэлгүй, соёлтой үйлчлэх чиглэлээр хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, илэрсэн зөрчилд хуульд заасан шийтгэл оногдуулах;	50	7	57	57
22	4.16.Нийслэлийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх тоон мэдээллийг хөтөлж, цахим сангийн баяжилтыг хийх, энэ чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах;	50	7	57	57
23	4.17.Хэлтсийн чиг үүргийн хүрээнд хийгдэж буй ажлын талаар холбогдох мэдээ, мэдээллийг боловсруулж иргэдэд мэдээлэх, удирдлагыг мэдээллээр хангах;	50	7	57	57
24	4.18.Хэлтсийн хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, албан хаагч, ажилтны ажлын цаг ашиглалтад хяналт тавих;	50	7	57	57
25	4.20.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын жолооч нарын дунд Уран жолоодлого-2024 тэмцээнийг зохион байгуулна.	50	7	57	57

26	4.21.Байгууллагын дотоод удирдлагын програмын ашиглалтыг хангаж ажиллах.	50	7	57	57
Дундаж оноо				**62 оноо**	**62 оноо**

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Нийслэлийн Засаг даргаас хэрэгжүүлэх төрийн албан хаагчийн сургалтад хамрагдах.	100%	15	15
2.	Арга хэмжээ 2. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах нийт сургалтад хамрагдах.	100%	15	15
3.	Арга хэмжээ 3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүд дээр ажиллах ур чадвараа сайжруулах.	100%	15	15
Дундаж оноо			**15 оноо**	**15 оноо**

Гурав. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (нэгжийн даргын үнэлгээ)

№	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
1.	Мэргэжлийн ур чадвар №1.	-	-
Дундаж оноо			**7 оноо**

Дөрөв. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (хамт олны үнэлгээ)

№	**Үзүүлэлт**	**Хамт олны үнэлгээ (0-8)**
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Баг, хамтын ажиллагаа	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		**8 оноо**

Тав. Гүйцэтгэлийн үнэлгээ

№	**Үнэлгээний үзүүлэлт**	**Үзүүлэлт тус бүрийн оноо**
	1	2
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (*Нэмэлт үүрэг даалгавар арга хэмжээний биелэлт*)	***62***
2.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	**15**
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	**7**
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	**8**

5	Үнэлгээний онооноо орсон өөрчлөлөт (*Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих*)	0.00
	Нийт оноо	92.0

Үнэлгээ өгсөн: ***Нэгжийн дарга***

Хяналт, шалгалтын хэлтсийн дарга ..... / Ц.Мягмар /

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.05 *(огноо)*

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Ахлах мэргэжилтэн ..... / Б.Мандхай/

(албан тушаал) *(гарын үсэг)*

..... *(огноо)*

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийн ахлагч:
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга ..... /З.Цэвээндорж/
(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.05 *(огноо)*

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн ажилтан ..... /М.Мөнх-Эрдэнэ/

(албан тушаал) *(гарын үсэг)*

..... *(огноо)*

Үнэлгээний багийн гишүүн:
Зорчигч, тээврийн хэлтсийн дарга ..... /Б.Дөлгөөн/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.10 *(огноо)*

Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... /Б.Бадамдорж/

(албан тушаал) *(гарын үсэг)* 2024.12.10 *(огноо)*

Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... /Д.Баясгалан/

(албан тушаал) *(гарын үсэг)*

..... *(огноо)*

Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн дарга ..... /С.Санжмятав/

(албан тушаал) *(гарын үсэг)*

12/10 *(огноо)*

Бүртгэл, техник технологийн хэлтсийн дарга ..... /М.Мөнхбаяр/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024-12-10 *(огноо)*

Захиргаа, удирдлагын хэлтсийн
Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болорцэцэг /Б.Болорцэцэг/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.10 *(огноо)*

Зорчигч тээврийн хэлтсийн Тээвэр зохицуулалт,
хариуцсан ахлах мэргэжилтэн ..... /Х.Баасансүрэн/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.10 *(огноо)*

Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн
Ачаа тээврийн төлөвлөлт, логистик хариуцсан,
ахлах мэргэжилтэн ..... /Ч.Ариунтуяа/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.10 *(огноо)*

Санхүү, аж ахуйн хэлтсийн
Эдийн засаг, төсвийн мэргэжилтэн ..... /Г.Даваадулам/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.10 *(огноо)*

Үнэлгээг баталгаажуулсан: ***Төсвийн шууд захирагч***

Нийтийн тээврийн бодлогын газрын дарга ..... /Д.Отгонжаргал/
(албан тушаал) *(гарын үсэг)*

..... *(огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
БАТТУЛГА ОВОГТОЙ МЯГМАРДОРЖИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт-ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. "Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ." НЗДҮАХ-6.3.15"							
1.	**Арга хэмжээ 1.1** Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид санал хүргүүлнэ. НХТ-418, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2	Хүргүүлсэн саналын тоо	-		Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргалын "Техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/53 тоот тушаалын дагуу тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Мягмар, Автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Мягмардорж, Техникийн хяналтын үзлэгийн төвийн ахлах менежер Э.Өлзий, Техникийн хяналтын үзлэгийн төвийн инженер Г.Ганбаатар нартай хамтарч Улаанбаатар хотоос Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх их багтаамжийн автобусны 28 үзүүлэлт бүхий техникийн шаардлагыг боловсруулсан.	2024.01.01 2024.12.31	100
Зорилт 2. "Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. 3.3, 5.2, 5.4.1,"							
1.	**Арга хэмжээ 2.1.** Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг журмын дагуу хяналт шалгалт хийж, хамтарсан шалгалтыг тогтмол хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх /5.1/	Зохион байгуулсан удирдамжтай хяналт шалгалтын тоо	-	1	2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад үзлэг шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийн хүрээнд "Зөрчлийн тухай" хууль, "Авто тээврийн тухай" хууль, "Төрийн хяналт шалгалтын тухай" хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох журам", Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага MNS5025:2020 стандартын хэрэгжилтийг хангуулах 11 иргэн, 3 аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалтыг хийж бичиг баримтыг хангуулж 2 иргэн, 5 байгууллагад ангиллын гэрчилгээ гаргуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	2024.01.01 2024.12.31	100

1	2	3	4	5	6	7	8
2.	**Арга хэмжээ 2.2.** Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шалгалт хийж удирдлагад мэдээлэл өгч ажиллах. /5.4.1./	Хэрэгжилт хүргүүлсэн тоо	-	-	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/1458 дугаар захирамжийн дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар)" төсөл, арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ"-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийн мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/298 тоот тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус томилогдон орж, 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд үүрэг гүйцэтгэн ажилласан. Ажлын хэсэгт орж гүйцэтгэсэн ажлууд: Үүнд: 1. 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын байранд "Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар)" төсөл, арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ"-нд заасан чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралд оролцож гүйцэтгэх ажил, үүргээ авсан; 2. Хятад улсад 2023-2024 онуудад үйлдвэрлэгдсэн Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн, евро-5 хөдөлгүүртэй, хар, саарал өнгийн 600 автобусны хүлээн авах ажлын хэсэг, дэд хэсгийн нийт 6 удаагийн хуралдаанд оролцож тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэлцэж, холбогдох үүрэг даалгаврыг авч ажилласан; 3. Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн парк шинэчлэлийн хүрээнд Хятад улсаас импортлон оруулж ирж байгаа Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн эхний ээлжинд орж ирсэн 35 шинэ автобусыг Сүхбаатарын талбайд Улаанбаатар хотын иргэдэд танилцуулах, зогсоолд зураглал үйлдэж байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд мэдээлэл өгөх, аж ахуйн нэгжид хамгаалан хүргэх ажлуудыг 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж гүйцэтгэсэн; 3. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 2 аж ахуйн нэгж байгууллагаас 9 удаагийн албан бичгээр ирүүлсэн их багтаамжийн автобуснуудыг нийтийн	2024.01.01 2024.12.31	12

1	2	3	4	5	6	7	8
					тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд бүртгүүлэх хүсэлтийн дагуу Хятад улсад 2023, 2024 онуудад үйлдвэрлэгдсэн Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн нийт 165 автобусны техникийн байдал болон жолооч нар нь Автотээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас дагаж мөрдүүлэхээр гаргасан журам, холбогдох стандартад нийцэх эсэхийг тогтоох зорилгоор үзлэг, шалгалт хийж, улсын байцаагчийн 1 дүгнэлт гаргасан; 4. Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн автобусыг Хятад улсаас батлагдсан хуваарийн дагуу хэсэгчлэн Улаанбаатар хотод оруулж ирэх үед цувааг 4 удаа Улаанбаатар хотын захын хэсгээс хүлээн авч, хамгаалан, эзэмших аж ахуйн нэгж, байгууллагуудад хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэсэн; 5. Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн 100 автобусыг аж ахуйн нэгж байгууллагуудын хооронд шилжүүлэн байршуулах ажлыг 4 удаа гүйцэтгэсэн.		
3. **"Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**							
	Арга хэмжээ 3.1. 2024 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Сая төгрөг	12	5	Тайлангийн хугацаанд нийт 11 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган 3.800.000 төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулан, санхүүгийн тооцоог хийж ажилласан. Нийт зөрчлийг төрлөөр нь ангилвал: нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч зорчих хөлс төлөөгүй зөрчил 21 буюу нийт зөрчил илрүүлэлтийн 42 %, тээвэрлэлтийн ажил үйлчилгээнд тухайн ангиллын мэргэшсэн жолооч ажиллуулаагүй зөрчил 9 буюу 18 %, ЕС зөршөөрөлгүй ачааны автомашинаар Нийслэл хотын доторх гудамж замын хөдөлгөөнд оролцсон зөрчил 20 буюу 10 %, холбогдох зөвшөөрөлгүйгээр ажилчид болон хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхэлсэн зөрчил 2 буюу 4 %, нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч холбогдох дүрэм, журам, стандарт зөрчсөн зөрчил 8 буюу 16 % болж байна.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 3.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	Үйл ажилгааны тоо	-	1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 10000 төгрөг хандивлан өөрийн биеээр очиж мод суулгасан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 3.3. Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд	Саналын тоо	-	1	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр нийтийн тээврийн үйлчилгээний автобусны зогсоолуудад их цэвэрлэгээ хийх 10 аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажил гүйцэтгэсэн.	2024.01.01 2024.12.31	12

	2	3	4	5	6	7	8
	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлд хяналт шалгалтаар гарсан дүн, мэдээллийг удирдлагат өгч ажиллана.				Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2021, "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013 улсын стандартуудын нэмэлт өөрчлөлтөд санал өгсөн.		
	Арга хэмжээ 3.4. Автотээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналт тавьж ажиллана. НХТ-426	Хяналт шалгалт хийсэн тоо	80	1	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 05/029/142 нийт 4 заалт бүхий улсын байцаагчийн зөрчил арилгуулах тухай хугацаатай 2 албан шаардлага өгч, 2 албан шаардлагын хариуг аван гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 3.5. Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах.	Сургалт хийсэн тоо	-	1	Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 22 ААНБ-ын 1350 жолоочид Нийслэл Улаанбаатар хотын , авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Нийтийн тээврийн бодлогын газар, Тээврийн цагдаагийн алба, Цагаан шонхорын жигүүр НҮТББ-уудтай хамтарсан сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 27-ны өдөрт зохион байгуулж гүйцэтгэсэн. Тус арга хэмжээний үеэр хүсэлт гаргасан 4 телевизид ярилцлага өгч, иргэдийг мэдээллээр ханган ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
Зорилт 4. "Дүрэм"-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: /А/88/							
	1	2	3	4	5	6	7
	Арга хэмжээ 4.1. Нийслэлийн нутаг	Хяналт шалгалт	10	5	Тайлангийн хугацаанд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүд тогтоосон чиглэл баримтлан ажиллаж буй	2024.01.01 2024.12.31	12
	2	3	4	5	6	7	8

	дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.1	хийсэн тоо			эсэхэд байнгын хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн. Шалгалтаар зөрчил илрээгүй.		
	Арга хэмжээ 4.2. Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.4	Хяналт шалгалт хийсэн тоо	10	5	Тайлангийн хугацаанд хууль бус нийтийн тээврийн үйлчилгээ /Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн болон хот доторх/ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажил гүйцэтгэж нийтийн тээврийн үйлчилгээг хууль бусаар эрхэлж байсан 5 суудлын автомашины жолоочид "Зөрчлийн тухай хууль"-ийн 14.6 дугаар зүйлийн 12-д заасны дагуу тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 4.3. Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажилд хяналт шалгалт хийнэ. Дүрмийн 4.1.6	Хяналт шалгалт хийсэн автотээврийн хэрэгслийн тоо	100	0	Нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгт ороход хяналт хийж ажилласан. Хүүхэд болон ажилчид тээвэрлэлтэд шугам замд хяналт шалгалт хийж Нийтийн тээврийн бодлогын газартай гэрээгүй хүүхэд тээвэрлэсэн 1, ажилчид тээвэрлэсэн 2 зөрчлийг илрүүлж, "Зөрчлийн тухай хууль"-ийн 14.6 дугаар зүйлийн 12-д заасны дагуу тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 4.4. Такси үйлчилгээний дуудлагын төв, дуудлагын төвийн жолооч, хүргэлтийн үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.8	Удирдамжтай хяналт шалгалт хийсэн тоо	3	1	Нийтийн тээврийн бодлогын газартай гэрээгүй, такси үйлчилгээний дуудлагын төв, дуудлагын төвийн жолооч, хүргэлтийн үйлчилгээнд шугам замд хяналт шалгалт хийж гэрээгүй зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн 3 жолоочид "Зөрчлийн тухай хууль"-ийн 14.6 дугаар зүйлийн 12-д заасны дагуу тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 4.5. Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, стандартын	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Тайлангийн хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээний том болон бага оврын автобус, таксийн үйлчилгээний, ажилчид тээвэрлэх, хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслээ шалгуулан улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж, бүртгэлийн санд бүртгүүлэх 16 албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч нийт 34 тээврийн хэрэгсэл болон жолооч нарыг шалгаж улсын байцаагчийн 16 дүгнэлт гаргасан. Үүнд: Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ	2024.01.01 2024.12.31	12
1	2	3	4	5	6	7	8

	шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, түвшин тогтоох /аттестатчилал/ явуулах ажилд удирдлага өгсөн үүргийн дагуу ажиллана. Дүрмийн 4.1.9				албан бичгээр ирүүлсэн их багтаамжийн автобуснуудыг нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд бүртгүүлэх хүсэлтийн дагуу Хятад улсад 2023 онд үйлдвэрлэгдсэн Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн нийт 5 автобусны техникийн байдал болон жолооч нар нь Автотээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас дагаж мөрдүүлэхээр гаргасан журам, холбогдох стандартад нийцэх эсэхийг тогтоох зорилгоор үзлэг, шалгалт хийж, улсын байцаагчийн 2024.08.22-5/029/142 тоот дүгнэлт гаргасан. Таксийн үйлчилгээний Юбикаб бригад хоршоо, Буянт хөлгийн жолоо хоршоо, Тэбэ сервис ХХК, Элит ноён такси ХХК, Мөнх такси ХХК-уудаас 13 албан бичгээр ирүүлсэн таксийн тээврийн хэрэгслийг бүртгэлийн санд бүртгүүлэх хүсэлтийн дагуу 22 суудлын автомашины техникийн байдал болон жолооч нар нь Автотээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас дагаж мөрдүүлэхээр гаргасан журам, холбогдох стандартад нийцэх эсэхийг тогтоох зорилгоор тус компаниудын хариуцсан албан тушаалтан болон жолооч нарыг байлцуулан үзлэг, шалгалт хийж, улсын байцаагчийн 2024.01.03 05/029/02, 2024.01.03 05/029/03, 2024.01.05-05/029/06, 2024.01.08 05/029/09, 2024.01.10 05/029/10, 2024.03.28 05/029/73, 2024.04.19 05/029/86, 2024.05.03 05/029/95. 2024.05.21 05/029/102, 2024.09.16 05/029/152, 2024.09.23, 05/029/154, 2024.11.05 05/029/192, 2024.11.08 05/029/195 тоот 11 дүгнэлт гаргасан. Үндэсний дата төв УТҮГ, Билэгт гүн богц ХХК-уудаас албан бичгээр ирүүлсэн дунд багтаамжийн хүүхдийн 1 автобус, ажилчдын дунд багтаамжийн 1автобусыг бүртгэлийн санд бүртгүүлэх хүсэлтийн дагуу 2 тээврийн хэрэгслийн техникийн байдал болон жолооч нь Автотээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас дагаж мөрдүүлэхээр гаргасан журам, холбогдох стандартад нийцэх эсэхийг тогтоох зорилгоор үзлэг, шалгалт хийж, улсын байцаагчийн 2024.06.12 05/029/121, 2024.11.24 05/029/197 тоот дүгнэлтүүдийг гаргасан.		
	Арга хэмжээ 4.6. Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж	Зөрчил гаргасан автотээврийн хэрэгслийн мэдээллийг E-Police системд	250	140	Хяналт шалгалтын хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хуулийг хэрэгжүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд хяналт тавих чиглэлээр Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн нутаг дэвсгэр дэх 10-р хороолол, Саппоро, 5 шар, 21-р хорооллын автобусны зогсоолуудад зорчигчдын буух, суух нөхцөлийг хангуулах, түр болон удаан хугацаагаар зогссон суудлын автомашины 44 зөрчлийг ЗХУТ-д шилжүүлж хариуцлага тооцуулан ажилласан.	2024.01.01 2024.12.31	12

1	2	3	4	5	6	7	8
	буй автотээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно. Дүрмийн 4.1.17	илгээсэн зөрчлийн тоо			Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн ажиллагаар хангах зорилгоор хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу нийт 22 удаа амралтын өдрөөр хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэн нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавьж ажилласан.		
	Арга хэмжээ 4.7. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах ажлын хүрээнд сургалт зохион байгуулна. Дүрмийн 4.1.18	Зохион байгуулсан сургалтын тоо	1	-	Нийтийн тээврийн үйлчилгээний Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 19-ний өдрүүдэд 10:00-11:30, 14:00-15:30 цагуудад тус газрын 1, 2, 3-р баазуудын нийтийн тээврийн үйлчилгээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр ажиллаж эхэлсэн нийт 342 жолоочид 6 удаагийн сургалтыг хийсэн. 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр НТБГ гэрээтэй Нийтийн зорчигч тээврийн үйляилгээ эрхлэгч ААНБ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй болон ашиглалтын инженерүүдэд "Галын аюулгүй байдлыг хангах нь" онол дадлага хосолсон сургалтыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах 26-р ангийн 2-р хэсэг, Сургалтыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага "MNS 4598:2020, "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2021 стандартуудын голчлон зөрчигддөг зүйл заалтуудаар явуулсан. Мөн хяналт, шалгалтын ажлын талаар, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас санал, гомдол хэрхэн ирдэг, барагдуулдаг талаар яриа, таниулга хийсэн.	2024.01.01 2024.12.31	12
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
	Арга хэмжээ 5.1.Стандарт, шаардлага хангасан хүүхдийн болон ажилчдын автобус, бусад тээврийн хэрэгслийг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчуулах, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх, зөвшөөрөл олгох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэн зохион байгуулна.	Дугаарын хязгаарлалтаас чөлөөлсөн автотээврийн хэрэгслийн тоо	10	5	Тайлангийн хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээний том болон бага оврын автобус, таксийн үйлчилгээний, ажилчид тээвэрлэх, хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслээ шалгуулан улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж, бүртгэлийн санд бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагууд "admin.ptd.ub.gov.mn" программаар хандсаныг хүлээн авч дүгнэлт гарган баталгаажуулж ажилласан.	2024.01.01 2024.12.31	12

	Арга хэмжээ 5.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн	Өргөдөл гомдлын хугацааг буруулж, зөрчлийн үзүүлэлтий	184	90	Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 1111 төвд иргэдээс ирүүлсэн 119 өргөдөл, гомдлыг, тус байгууллагын иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах 70047004 утсаар иргэдээс ирүүлсэн 41, Нийтийн тээвэр-Public transport UB цахим хаягаар ирсэн 1, нийт 161 санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч 100 хувь барагдуулж ажилласан. Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн 6	2024.01.01 2024.12.31	12
1	2	3	4	5	6	7	8
	шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгөх, өргөдөл, гомдлын хугацаанд нь барагдуулж, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	г бууруулах хувь			албан бичгийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн.		
Зорилт 6. Хэлтсийн чиг үүргийн хүрээнд							
	Арга хэмжээ 6.1.Нийслэлийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын шаардлагад хяналт тавих, энэ чиглэлээр тээвэрлэгч аж ахуй нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн хувьд зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцож ажиллана;	Хийгдсэн арга хэмжээний тоо	10	3	Тайлангийн хугацаанд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллагын 2800 тээврийн хэрэгслийн жолооч нарыг Автотээвэрийн тухай хууль, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг хэрхэн хангаж үйлчилгээнд ажиллаж байгаад хяналт шалгалт хийж, 104 жолоочийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 11 холбогдогчид Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 хэсэгт заасныг үндэслэн 400.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцон ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.2. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	Хяналт шалгалтын тоо	10	4	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй ажилладаг 14 аж ахуйн нэгж, байгууллагын нийтийн тээврийн үйлчилгээний удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, сүүлийн 2 сар нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаагүй 14 тээврийн хэрэгслийн шалтгаан нөхцлийг тодруулах зорилгоор тус компаниудад Улаанбаатар Смарт карт	2024.01.01 2024.12.31	12

					ХХК-ийн ТЗҮХ-ийн дарга М.Батбилгүүнтэй хамтарч 2024 оны 03 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд хяналт, шалгалтын ажил гүйцэтгэсэн. Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргалын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталсан "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд тээврийн хэрэгслийн угаалга, цэвэрлэгээг хэрхэн гүйцэтгэж байгаад хийх шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээ		
1	2	3	4	5	6	7	8
					байгуулан ажилладаг Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 2-р баазын үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслүүдэд хийгдэж буй угаалга, цэвэрлэгээний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргалын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталсан "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд тээврийн хэрэгслийн угаалга, цэвэрлэгээг хэрхэн гүйцэтгэж байгаад хийх шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй ажилладаг Автобус нэгдэл ХХК, Трансбус ХХК-ийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслүүдэд хийгдэж буй угаалга, цэвэрлэгээний үйл ажиллагаанд холбогдох стандарт, дүрэм, журам хэрхэн хангагдаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг хийсэн.		
	Арга хэмжээ 6.3. Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	Хяналт шалгалтын тоо	40	15	Тайлангийн хугацаанд Нийслэл хотын доторх гудамж замын хөдөлгөөнд ачаа тээвэрлэлтийн ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа 1120 ачааны автомашинд "Автотээврийн тухай хууль"-ийн хэрэгжилт, "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм"-ийн мөрдөлт, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага"MNS4598:2020, "Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага" MNS4978:2017, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг" MNS5029:2011 улсын стандартуудын үзүүлэлт шаардлагыг хэрхэн хангаж буйд мөн Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүд ачааны авто машинд холбогдох зөвшөөрлүүдийг /ЕС зөвшөөрөл, түр зөвшөөрөл/ авч хөдөлгөөнд оролцож буй эсэх, тээвэрлэлтийн ажил үйлчилгээнд тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч ажиллуулж буй эсэхэд тус тус хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн. Шалгалтыг зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хариуцлага тооцох чиглэлээр гүйцэтгэж, зөрчил гаргасан 4 аж	2024.01.01 2024.12.31	12

					ахуйн нэгж, байгууллага, 4 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасныг үндэслэн нийт 1.100.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулан, 100 хувь барагдуулан ажилласан.		
	Арга хэмжээ 6.4. Хүүхдийн болон ажилчдын автобусны үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	Хяналт шалгалтын тоо	40	20	Тайлангийн хугацаанд ажилчид тээвэрлэдэг 25 тээврийн хэрэгслийг шалгаж, холбогдох зөвшөөрөлгүйгээр ажилчид тээвэрлэх үйлчилгээ эрхэлсэн 1 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасныг үндэслэн 250.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. Тайлангийн хугацаанд хүүхэд тээвэрлэдэг 13 тээврийн хэрэгслийг шалгаж, холбогдох зөвшөөрөлгүйгээр хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхэлсэн 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үндэслэн 100.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.5. Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	Хяналт шалгалтын тоо	20	-	Тайлангийн хугацаанд авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хийх шалгалт хийх талаар хяналт шалгалтын хэлтсээс хуваарьт тавиагүй. Шалгалт хийсэн байцаагч нар хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу шалгалт явуулсан болно	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.6. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийн мэдээллээр гэрээний хариуцлага /анз/ хүлээлгэх.	Саналын тоо	10	3	Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргалын өгсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний Эрдэмтранс ХХК-ийн Налайх дүүрэгт байрлах 3-р баазын гарааш, засварын цех, зогсоолын талбай болон бусад объектуудад Автотээврийн хяналтын улсын байцаагч О.Батцоожтой хамтран хэсгийн дарга Б.Одбаатар, шалгах механик Т.Мөнх-Эрдэнэ нарыг байлцуулан үзлэг, шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авч ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.7. Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн хяналт шалгалтын бусад байгууллагатай хамтран ажиллана;	Хамтран хийгдэх хяналт шалгалтын тоо	2	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй ажилладаг 14 аж ахуйн нэгж, байгууллагын нийтийн тээврийн үйлчилгээний удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, сүүлийн 2 сар нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаагүй 67 тээврийн хэрэгслийн шалтгаан нөхцлийг тодруулах зорилгоор тус компаниудад Улаанбаатар Смарт карт ХХК-ийн ТЗҮХ-ийн дарга М.Батбилгүүнтэй хамтарч 2024 оны 03 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд хяналт, шалгалтын ажил гүйцэтгэсэн.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.8. Автотээврийн тухай хууль түүнд нийцүүлэн	Автотээврийн	2000	1000	2024 оны эхний хагас жилийн байдлаар 50 зөрчилд торгох шийтгэл оногдуулсанаас: нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч зорчих хөлс төлөөгүй зөрчил 21 буюу нийт зөрчил илрүүлэлтийн 42 %, тээвэрлэлтийн ажил	2024.01.01 2024.12.31	12

	гаргасан дүрэм, журам стандартын шаардлагыг хангуулах зорилгоор шугам замын шалгалт хийх;	хэрэгслийн тоо			үйлчилгээнд тухайн ангиллын мэргэшсэн жолооч ажиллуулаагүй зөрчил 9 буюу 18 %, ЕС зөршөөрөлгүй ачааны автомашинаар Нийслэл хотын доторх гудамж замын хөдөлгөөнд оролцсон зөрчил 10 буюу 20 %, холбогдох зөвшөөрөлгүйгээр ажилчид болон хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхэлсэн зөрчил 2 буюу 4 %, нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч холбогдох дүрэм, журам, стандарт зөрчсөн зөрчил 8 буюу 16 % болж байна.		
	Арга хэмжээ 6.10. Нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих иргэдийн төлбөр төлөх байдалд шалгалт явуулж, хуульд заасны дагуу шаардлага тавих, хөлс төлөөгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах, жолооч зорчигчдын эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчил хариулага тооцож ажиллана.	Хийгдсэн шалгалтын тоо	70	35	Нийтийн тээврийн газрын даргын баталсан "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих шалгалтын удирдамж"-ийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд тус байгууллагын хяналтын ажилтан, шалгагч нартай хамтран Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Хяналт шалгалтын хэлтсээс гаргасан хуваарийн дагуу зорчигчийн хөлс төлөлтийн байдалд хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн. Шалгалтад 365 тээврийн хэрэгсэл 12650 зорчигч хамрагдсан. Шалгалтыг Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Автотээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан дүрэм, журмын хэрэгжилт, зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавьж, хууль, дүрэм таниулах, мэдээлэл сурталчилгаа хийх, зөвлөмж материал тараах, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх, зорчигчдыг картжуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох чиглэлээр гүйцэтгэсэн. Тайлангийн хугацаанд зорчих хөлс төлөөгүй зөрчил гаргасан 19 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн нийт 190.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж 100 хувь барагдуулан ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.11. Аюултай болон тусгай ачаа тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх илэрсэн зөрчилд хариуцлага тооцох.	Хяналт шалгалтын тоо	4	2	Тайлангийн хугацаанд Нийслэл хотын доторх гудамж замын хөдөлгөөнд ачаа тээвэрлэлтийн ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа 1120 ачааны автомашинд "Автотээврийн тухай хууль"-ийн хэрэгжилт, "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм"-ийн мөрдөлт, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага"MNS4598:2020, "Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага" MNS4978:2017, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг" MNS5029:2011 улсын стандартуудын үзүүлэлт шаардлагыг хэрхэн хангаж хөдөлгөөнд оролцож буй эсэх, тээвэрлэлтийн ажил үйлчилгээнд тухайн ангиллын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч ажиллуулж буй эсэхэд тус тус хяналт шалгалтын ажил гүйцэтгэсэн. Шалгалтыг зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хариуцлага тооцох чиглэлээр гүйцэтгэсэн.	2024.01.01 2024.12.31	12

	Арга хэмжээ 6.12. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах зорилгоор орчин үеийн цахим техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж ашиглах зэргээр ажлын бүтээмжийг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээнд саналаа тусгуулж ажиллах;	Хийгдсэн ажлын тоо	1	1	Нийтийн тээврийн бодлогын газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Тээврийн загдаагийн алба, Цагаан шонхор ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг газруудтай хамтран гэмт хэрэг, зөрчил гарахаас урдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулж ажилласан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.13. Нийслэлийн нийтийн тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах болон гудамж замд эвдэрч саатсан нийтийн тээврийн хэрэгслийг шуурхай чөлөөлөх зэрэг үйл ажиллагаанд тогтмол шалгалт хийж, илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллана;	Тухай бүр заасан шийтгэл оногдуулах ;	5	-	Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга Г.Батзориг "Дүүргийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдалд түүвэрчилсэн хяналт шалгалт явуулах ажлын удирдам"-ийн хүрээнд УБЗАА-ны Тохижилт , хог хаягдлын удирдлагын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Мөнхбаяр нартай хамтран Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хот тохижилтын аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийж Тээвэр цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслүүдийн замын хөдөлгөөнд оролцуулсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, дахин зөрчил гаргахгүй ажиллах зөвлөн туслах зааварчилгаа өгч ажиллалаа.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.14. Нийтийн тээврийн автобус, тролейбус чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээнээс бусад эгнээгээр зорчуулахгүй байх, чиглэлийн тээврийн хэрэгслийн буудалд зөв байрлуулах,	Илрүүлсэн зөрчлийн тоо	40	20	Хяналт шалгалтын хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хуулийг хэрэгжүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд хяналт тавих чиглэлээр Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн нутаг дэвсгэр дэх 10-р хороолол, Саппоро, 5 шар, 21-р хорооллын автобусны зогсоолуудад зорчигчдын буух, суух нөхцөлийг хангуулах, түр болон удаан хугацаагаар зогссон суудлын автомашины 24 зөрчлийг ЗХУТ-д шилжүүлж хариуцлага тооцуулан ажилласан.	2024.01.01 2024.12.31	12

	иргэдэд тав тухтай, соёлтой үйлчлэх чиглэлээр хяналт шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчилд хуульд заасан шийтгэл оногдуулах;						
	Арга хэмжээ 6.15. Автотээврийн үйлчилгээ эрхлэх явцад зам, тээврийн осол гарсан тохиолдолд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, дахин зөрчил гаргахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, уг зам тээврийн осол, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тогтоож, бүрүүтай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх;	Тухай бүр	3	1	Эрдэмтранс ХХК-ийн Замын хажуугын гэрлийн шон мөргөсөн автобусанд газар дээр нь очиж бичиг баримтын бүрдэлтийг хангуулж удирдлагуудыг мэдээллээр хангаж ажилласан. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шугам замд байнгын хяналт шалгалтын ажил гүйцэтгэн 220 жолоочийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж, зөвлөн тусалсан.		12
	Арга хэмжээ 6.16. Хэлтсийн хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Тухай бүр	-	2	Нийтийн тээврийн бодлогын газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Мягмар хэлтсийн нийт албан хаагч нарт сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах сургалтыг зохион байгуулсан.	2024.01.01 2024.12.31	12
	Арга хэмжээ 6.17. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч нарын дунд Уран жолоодлого-2024 тэмцээний зохион байгуулахад оролцох.	Зохион байгуулсан тэмцээний тоо	1	1	Нийтийн тээврийн бодлогын газартай гэрээтэй Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын дунд 2024 оны 09 дүгээр сарын 14 -нд зохион байгуулсан уран жолоодлогын тэмцээнд дундын зогсоолын шүүгчээр ажилласан.	2024.01.01 2024.12.31	12

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.				Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргалын "Техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/53 тоот тушаалын дагуу тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Мягмар, Автотээврийн хяналтын улсын байцаагч М.Мөнхзул, Техникийн хяналтын үзлэгийн төвийн ахлах менежер Э.Өлзий, Техникийн хяналтын үзлэгийн төвийн инженер Г.Ганбаатар нартай хамтарч Улаанбаатар хотоос Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх их багтаамжийн автобусны үзүүлэлт бүхий техникийн шаардлагыг боловсруулахад саналаа өгж оролцсон.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.				Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв"-д тус байгууллагын Автотээврийн хяналтын улсын байцаагч нарын "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ" хийлгэх хүсэлтийг хүргүүлж, тус төвтэй ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх гэрээ байгуулан ажиллахад саналаа өгч ажилласан.		
3.	.....						

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1.				2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Пума империал зочид буудалд Инфокон ХХК-аас зохион байгуулагдсан "Нийтийн тээврийн мэдээллийн нэгдсэн систем"-ийн хэрэглээний сургалтад оролцсон. 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 08:00 цагаас Нийслэлийн Засаг захиргааны 5-р байранд Нийслэлийн		

					Хүний нөөцийн хөгжлийн төвийн сургагч багш Т.Оюундарийн зохион байгуулсан “Зөрчлийг удирдахуй” сэдэвт сургалтад хамрагдсан.		
2.	Арга хэмжээ 2.				2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 14:00 цагаас UB Palace-ийн их танхимд зохион байгуулсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарын зохион байгуулсан “Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын уулзалт”-д оролцсон.		
3.	……				2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нийтийн тээврийн хэрэгсэлд суурилуулсан камерыг хэрхэн ажиллуулах талаар гүйцэтгэгч байгууллагын зохион байгуулсан сургалтад оролцсон.		

ТАЙЛАН ГАРГАСАН:
Автотээврийн хяналтын улсын байцаагч

…… …… / Б.Мягмардорж / 2024 . 11 . 05

(Албан тушаал) *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Б.МЯГМАРДОРЖИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Нийтийн тээврийн бодлогын газар

Нэгжийн нэр: Хяналт, шалгалтын хэлтэс

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ." НЗДҮАХ-6.3.15"					
1.	**Арга хэмжээ 1.1** Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид санал хүргүүлнэ. НХТ-418, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2	60	10	70	70
Зорилт 2. "Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. 3.3, 5.2, 5.4.1,"					
1.	**Арга хэмжээ 2.1.** Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг журмын дагуу хяналт шалгалт хийж, хамтарсан шалгалтыг тогтмол хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх /5.1/	60	10	70	70
2	**Арга хэмжээ 2.2.** Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шалгалт хийж удирдлагад мэдээлэл өгч ажиллах. /5.4.1./	60	10	70	70
3. "Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:					
3	**Арга хэмжээ 3.1.** 2024 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	60	10	70	70

4	**Арга хэмжээ 3.2.** "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	60	10	70	70
5	**Арга хэмжээ 3.3.** Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлд хяналт шалгалтаар гарсан дүн, мэдээллийг удирдлагад өгч ажиллана.	60	10	70	70
6	**Арга хэмжээ 3.4.** Автотээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналт тавьж ажиллана. НХТ-426	60	10	70	70
7	**Арга хэмжээ 3.5.** Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах.	60	10	70	70
	Зорилт 4. "Дүрэм"-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: /А/536/				
8	**Арга хэмжээ 4.1.** Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.1	60	10	70	70
9	**Арга хэмжээ 4.2.** Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.4	60	10	70	70
10	**Арга хэмжээ 4.3.** Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажилд хяналт шалгалт хийнэ. Дүрмийн 4.1.6	60	10	70	70
11	**Арга хэмжээ 4.4.** Такси үйлчилгээний дуудлагын төв, дуудлагын төвийн жолооч, хүргэлтийн үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.8	60	10	70	70
12	**Арга хэмжээ 4.5.** Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, стандартын шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, түвшин тогтоох /аттестатчилал/ явуулах ажилд удирдлага өгсөн үүргийн дагуу ажиллана. Дүрмийн 4.1.9	60	10	70	70
13	**Арга хэмжээ 4.6.** Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй автотээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно. Дүрмийн 4.1.17	60	10	70	70
14	**Арга хэмжээ 4.7.** Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах	60	10	70	70

	ажлын хүрээнд сургалт зохион байгуулна. Дүрмийн 4.1.18				
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:					
15	**Арга хэмжээ 5.1.** Стандарт, шаардлага хангасан хүүхдийн болон ажилчдын автобус, бусад тээврийн хэрэгслийг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчуулах, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх, зөвшөөрөл олгох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэн зохион байгуулна.	60	10	70	70
16	**Арга хэмжээ 5.2.** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгөх, өргөдөл, гомдлын хугацаанд нь барагдуулж, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	50	6	56	56
Зорилт 6. Хэлтсийн чиг үүргийн хүрээнд					
17	**Арга хэмжээ 6.1.** Нийслэлийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын шаардлагад хяналт тавих, энэ чиглэлээр тэзвэрлэгч аж ахуй нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн хувьд зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцож ажиллана;	50	6	56	56
18	**Арга хэмжээ 6.2.** Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	50	6	56	56
19	**Арга хэмжээ 6.3.** Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	50	6	56	56
20	**Арга хэмжээ 6.4.** Хүүхдийн болон ажилчдын автобусны үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	50	6	56	56
21	**Арга хэмжээ 6.5.** Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	50	6	56	56
22	**Арга хэмжээ 6.7.** Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийн мэдээллээр гэрээний хариуцлага /анз/ хүлээлгэх.	50	6	56	56
23	**Арга хэмжээ 6.8.** Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн хяналт шалгалтын бусад байгууллагатай хамтран ажиллана;	50	6	56	56
24	**Арга хэмжээ 6.9.** Автотээврийн тухай хууль түүнд нийцүүлэн гарагасан дүрэм,	50	6	56	56

	журам стандартын шаардлагыг хангуулах зорилгоор шугам замын шалгалт хийх;				
25	**Арга хэмжээ 6.10.** Нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих иргэдийн төлбөр төлөх байдалд шалгалт явуулж, хуульд заасны дагуу шаардлага тавих, хөлс төлөөгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах, жолооч	50	6	56	56
26	**Арга хэмжээ 6.11.** Аюултай болон тусгай ачаа тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх илэрсэн зөрчилд хариуцлага тооцох.	50	6	56	56
27	**Арга хэмжээ 6.12.** Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах зорилгоор орчин үеийн цахим техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж ашиглах зэргээр ажлын бүтээмжийг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээнд саналаа тусгуулж ажиллах;	50	6	56	56
28	**Арга хэмжээ 6.13.** Нийслэлийн нийтийн тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах болон гудамж замд эвдэрч саатсан нийтийн тээврийн хэрэгслийг шуурхай чөлөөлөх зэрэг үйл ажиллагаанд тогтмол шалгалт хийж,	50	6	56	56
29	**Арга хэмжээ 6.14.** Нийтийн тээврийн автобус, тролейбус чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээнээс бусад эгнээгээр зорчуулахгүй байх, чиглэлийн тээврийн хэрэгслийн буудалд зөв байрлуулах, иргэдэд тав тухтай, соёлтой үйлчлэх чиглэлээр хяналт шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчилд хуульд заасан шийтгэл оногдуулах;	50	6	56	56
30	**Арга хэмжээ 6.15.** Автотээврийн үйлчилгээ эрхлэх явцад зам, тээврийн осол гарсан тохиолдолд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, дахин зөрчил гаргахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, уг зам тээврийн осол, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тогтоож, буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх;	50	6	56	56
31	**Арга хэмжээ 6.16.** Хэлтсийн хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	50	6	56	56
32	**Арга хэмжээ 6.17.** Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч нарын дунд Уран жолоодлого-2024 тэмцээний зохион байгуулахад оролцох.	50	6	56	56
Дундаж оноо				**63 оноо**	**63 оноо**

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Нийслэлийн Засаг даргаас хэрэгжүүлэх төрийн албан хаагчийн сургалтад хамрагдах.	100%	12	12
2.	Арга хэмжээ 2. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах нийт сургалтад хамрагдах.	100%	12	12
3.	Арга хэмжээ 3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүд дээр ажиллах ур чадвараа сайжруулах.	100%	12	12
Дундаж оноо			**12 оноо**	**12 оноо**

Гурав. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (нэгжийн даргын үнэлгээ)

№	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
1.	Мэргэжлийн ур чадвар №1. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийх.	7	7
Дундаж оноо			**7 оноо**

Дөрөв. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (хамт олны үнэлгээ)

№	**Үзүүлэлт**	**Хамт олны үнэлгээ (0-8)**
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Баг, хамтын ажиллагаа	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		**8 оноо**

Тав. Гүйцэтгэлийн үнэлгээ

№	**Үнэлгээний үзүүлэлт**	**Үзүүлэлт тус бүрийн оноо**
	1	2
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (*Нэмэлт үүрэг даалгавар арга хэмжээний биелэлт*)	***63***
2.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	**12**
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	**7**

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний онооноо орсон өөрчлөлөт (*Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих*)	0.00
Нийт оноо		90.0

Үнэлгээ өгсөн: ***Нэгжийн дарга***

Хяналт, шалгалтын хэлтсийн дарга ..... / Ц.Мягмар /

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.05 *(огноо)*

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Автотээврийн хяналтын улсын байцаагч ..... /Б.Мягмардорж/

(албан тушаал) *(гарын үсэг)*

2024.12.05 *(огноо)*

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийн ахлагч:
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга ..... /З.Цэвээндорж/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн ажилтан ..... /М.Мөнх-Эрдэнэ/
(албан тушаал) *(гарын үсэг)*
..... *(огноо)*

Үнэлгээний багийн гишүүн:
Зорчигч, тээврийн хэлтсийн дарга ..... /Б.Дөлгөөн/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... /Б.Бадамдорж/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... /Д.Баясгалан/
(албан тушаал) *(гарын үсэг)*
..... *(огноо)*

Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн дарга ..... /С.Санжмятав/
(албан тушаал) *(гарын үсэг)*
..... *(огноо)*

Бүртгэл, техник технологийн хэлтсийн дарга ..... /М.Мөнхбаяр/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Захиргаа, удирдлагын хэлтсийн
Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болорцэцэг /Б.Болорцэцэг/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Зорчигч тээврийн хэлтсийн Тээвэр зохицуулалт,
хариуцсан ахлах мэргэжилтэн ..... /Х.Баасансүрэн/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Хяналт, шалгалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн Б.Мандхай /Б.Мандхай/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн
Ачаа тээврийн төлөвлөлт, логистик хариуцсан,
ахлах мэргэжилтэн ..... /Ч.Ариунтуяа/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Санхүү, аж ахуйн хэлтсийн
Эдийн засаг, төсвийн мэргэжилтэн ..... /Г.Даваадулам/
(албан тушаал) *(гарын үсэг)*
2024.12.10 *(огноо)*

Үнэлгээг баталгаажуулсан: ***Төсвийн шууд захирагч***

Нийтийн тэээврийн бодлогын газрын дарга ..... /Д.Отгонжаргал/
(албан тушаал) *(гарын үсэг)*
..... *(огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ МӨНХБААТАР ОВОГТОЙ МӨНХЗУЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. "Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ." НЗДҮАХ-6.3.15"							
1.1	Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид санал хүргүүлнэ. НХТ-418, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2	Хүргүүлсэн саналын тоо			Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор Автотээврийн хяналтын улсын байцаагч нарын саналыг тусгуулж, нийтийн тээврийн чиглэлийн төлөвлөлт /богино эргэлт, дундын эх авалт, буудал бүрээс нэгэн зэрэг эх авалт/ иргэдээс ирсэн саналын дагуу судалгааг үндэслэн нийтийн тээврийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөж гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажилласан.	01-12	100
Зорилт 2. "Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. 3.3, 5.2, 5.4.1,"							
2.1	Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг журмын дагуу хяналт шалгалт хийж, хамтарсан шалгалтыг тогтмол хийж, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх /5.1/	Зохион байгуулсан удирдамжтай хяналт шалгалтын тоо	1	1	Зам, Тээврийн яамнаас 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 07/3103 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийтийн тээврийн бодлогын газрын даргын баталсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалтын ажлын удирдамж"- ийн хүрээнд Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт авто засвар, авто угаалга ажиллуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам", "Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага" MNS 5025:2020, "Авто машины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага" MNS 5347:2003 улсын стандартуудын хэрэгжилт, техникийн аюулгүй ажиллагаа ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын заавар, журам хэрхэн мөрдөж байгаад хяналт, шалгалтаар "Межик инженерийг авто" ХХК-ийн ангилалыг	01-12	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
					гэрчилгээгүй дугуй худладаа эрхэлсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасаныг үндэслэн 500 нэгжтээр торгох шийтгэл 254794 дугаартай шийтгэлийн хуудсаар оногдуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаа.		
2.2	Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний	Хэрэгжилт хүргүүлсэн тоо	-	-	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/1458 дугаар захирамжийн дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Нийтийн тээврийн автобус (Улаанбаатар)" төсөл, арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ"-нд заасны дагуу нийлүүлэгдсэн автобус хуваарилагдсан аж ахуйн нэгжүүдийн талбайд байршуулах ажлыг, 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн Ажлын хэсэгт орж гүйцэтгэсэн ажлууд; . Yutong маркийн ZK6116HG загварын, их багтаамжийн автобусыг Хятад улсаас батлагдсан хуваарийн дагуу хэсэгчлэн Улаанбаатар хотод оруулж ирэх үед "Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-ыг гарааш болон гадна талбайн байршуулах ажлыг 5 удаа зохион байгуулж аюулгүй байдлыг хангуулж, ашиглах, эзэмших аж ахуйн нэгж, байгууллагуудад хүлээлгэн өгөх 2 удаа аюул осолгүй гүйцэтгэж 760 автобусны техникийн дүгнэлт гаргасан; . Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргалын "Техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/53 тоот тушаалын дагуу тус ажлын хэсгийн томилогдож Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх их багтаамжийн автобусны 28 үзүүлэлт бүхий техникийн шаардлагыг боловсруулсан хүргүүлсэн.	01-12	100
3. "Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
3.1	2024 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Сая төгрөг	12	8.5	11.375.000 төгрөгийн торгууль оногдуулж улсын төсөвт төвлөрүүлсэн. 3 аж ахуйн нэгжид холбогдох зөрчлийг хянан шалгаж байна.	01-12	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	Үйл ажилгааны тоо	-	1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сард Баянгол дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 100 ширэг мод тарих ажилд оролцсон.	01-12	100
3.3	Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хороол лыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжил тийг хангах ажлын хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлд хяналт шалгалтаар гарсан дүн, мэдээллийг удирдлагат өгч ажиллана.	Саналын тоо	-	1	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2021,"Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013 улсын стандартуудын нэмэлт өөрчлөлтөд санал өгсөн. 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Ажил гүйцэтгэх гэрээ-ний /Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх/ өөрчлөлтөд санал өгсөн. Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын даргын баталсан "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлтийг"А/63 ажлын хэсэг гишүүнээр томилогдож Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-уудад гэрээ байгуулхад шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж санал тусгуулж ажиллав.	01-12	100
3.4	Автотээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналт тавьж ажиллана. НХТ-426	Хяналт шалгалт хийсэн тоо	80	1	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч ДЮЦ ХХК, Трансбус ХХК, ЭМСИД ХХК-уудын үйл ажиллагаанд шалгалт хийж 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдөр 05/028/06, 05/028/07, 05/028/08 тоот нийт 3 заалт бүхий улсын байцаагчийн зөрчил арилгуулах тухай хугацаатай 3 албан шаардлага өгч, ирүүлсэн хариуг авч гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган ажилласан.	01-12	100
3.5	Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах.	Сургалт хийсэн тоо	-	1	1. Нийтийн тээврийн бодлогын газраас, Тээврийн цагдаагийн алба хамтран хэрэгжүүлэх чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих, чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоолд түр болон удаа хугацаагаар зогсож байгаа тээврийн хэрэгслүүдийн зөрчлийг зургаар баримтжуулан замын хөдөлгөөний удирдлагын төврүү илгээж хариуцлага тооцуулах тухай мэдээллийг тээврийн цагдаагийн хэвлэл мэдээллийн албанд мэдээлэл өгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажилласан. 2.Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр "Тэнгэр плаза" худалдааны төвөөс Бага нуур дүүрэг чиглэлд тээвэрлэлтийн гэрээгүй, стандартын шаардлага хангаагүй тээврийн хэргэслээр зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр Нийтийн тээврийн газар, Автотээврийн үндсэн төв ТӨҮГ, Баянзүрх дүүргийн тамгын газар хамтарсан ажлын хэсэг	01-12	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					ажиллаж хэвлэл мэдээллийн хэрэгслэлд мэдээлэл өгч гарсан зөрчилд торгох шийтгэл оногдуулж ажиллав.		
Зорилт 4. "Дүрэм"-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: /А/536/							
4.1	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.1	Хяналт шалгалт хийсэн тоо	10	5	Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах зорилгоор хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу нийт 14 удаа амралтын өдрөөр хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэн нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавьж ажилласан. Ардын хувьсгалын 103 жилийн ойн баяр наадамтай холбогдуулан 2024 оны 07 дугаар сарын 12-ны өдөр 08:00-22:00 цагийн хоорондох хугацаанд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх Төв цэнгэлдэх хүрээлэнгийн автобусны зогсоолд, 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд 08:00-22:00 цагийн хоорондох хугацаанд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр дэх Хүй долоон худгийн автобусны зогсоолд нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдэд хяналт тавьж, шуурхай зохицуулалт хийж ажилласан.	01-12	100
4.2	Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэнэ. Дүрмийн 4.1.4	Хяналт шалгалт хийсэн тоо	10	5	Тайлангийн хугацаанд нийт 152 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган 11375000 төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулан, санхүүгийн тооцоог хийж ажилласан. Нийт зөрчлийг төрлөөр нь ангилвал: нийтийн тээврийн хэрэгслийн жолоочийн гаргасан зөрчил 37.5 %, тээвэрлэлтийн ажил үйлчилгээнд тухайн ангиллын мэргэшсэн жолооч ажиллуулаагүй зөрчил 14.3 %, Хот болон хот орчмын нутаг дэвсгэр ачааны автомашинаар ороцохдоо замын чиглэле, хугацаа агуулсан зөвшөөрөлгүй 3.8 %, холбогдох зөвшөөрөлгүйгээр ажилчид болон хүүхэд тээвэрлэх үйлчилгээ эрхэлсэн зөрчил 3.8 %, нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч холбогдох дүрэм, журам, стандарт зөрчсөн зөрчил 14.3 %, албан шаардлага биелүүлээгүй зөрчил 14.3 %, тээвэрлэлтийн гэрээгүйгээр нийтийн тээврийн үйлчилгээнд ажилласан зөрчил 1.8 %, зорчих хөлс төлөөгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах үүргээ биелүүлээгүй зөрчил 10.7 %, тамхи татсан зөрчил 1.8 %, зорчигчийн тав тухтай зорчих нөхцлийг хангаагүй зөрчил 5.3 % болж байна.	01-12	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.3	Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажилд хяналт шалгалт хийнэ. Дүрмийн 4.1.6	Хяналт шалгалт хийсэн автотээврийн хэрэгслийн тоо	5	5	Тайлангийн хугацаанд сургуулийн болон ажилчдын 35 автобусыг шалгаж холбогдох зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ эрхэлсэн 2 аж ахуйн нэгж, 4 хувь хүнд холбогдох зөрчлийн хялбаршуулсан журмаар Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн үндсэлэн торгох шийтшэл оногдуулсан.	01-12	100
4.4	Такси үйлчилгээний дуудлагын төв, дуудлагын төвийн жолооч, хүргэлтийн үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.8	Удирдамжтай хяналт шалгалт хийсэн тоо	1	1	Тайлангийн хугацаанд хууль бус нийтийн тээврийн үйлчилгээ /Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн болон хот доторх/ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажил гүйцэтгэж нийтийн тээврийн үйлчилгээг хууль бусаар эрхэлж байсан 6 суудлын автомашины жолоочид "Зөрчлийн тухай хууль"-ийн 14.6 дугаар зүйлийн 12-д заасны дагуу тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан.	01-12	100
4.5	Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, стандартын шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, түвшин тогтоох /аттестатчилал/ явуулах ажилд удирдлага өгсөн үүргийн дагуу ажиллана. Дүрмийн 4.1.9	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Нийтийн тээврийн газрын даргын А/63 дугаар тушаалаар баталсан Хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хэлэлцүүлхээр ирүүлсэн, Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ, И-такси ХХК-уудын гаргасан хүсэлтийг авч хэлэлцэн холбогдох шаардлага хангаж байгаа эсэх талаар ажлын хэсэг шийдвэр гаргаж ажилласан	01-12	100
4.6	Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксийн зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй автотээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно. Дүрмийн 4.1.17	Зөрчил гаргасан автотээврийн хэрэгслийн мэдээллийг E-Police системд илгээсэн зөрчлийн тоо	250	150	Хяналт шалгалтын хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хуулийг хэрэгжүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд хяналт тавих чиглэлээр Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн нутаг дэвсгэр дэх 10-р хороолол, Саппоро, 5 шар, 21-р хороллын автобусны зогсоолуудад зорчигчдын буух, суух нөхцөлийг хангуулах, түр болон удаан хугацаагаар зогссон суудлын автомашины 300 зөрчлийг ЗХУТ-д шилжүүлж хариуцлага тооцуулан ажилласан.	01-12	100
4.7	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг	Зохион байгуулсан	1	-	Тайлант хугацаанд хийгдээгүй.	01-12	0

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах ажлын хүрээнд сургалт зохион байгуулна. Дүрмийн 4.1.18	сургалтын тоо					
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
5.1	Стандарт, шаардлага хангасан хүүхдийн болон ажилчдын автобус, бусад тээврийн хэрэгслийг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчуулах, дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх, зөвшөөрөл олгох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэн зохион байгуулна.	Дугаарын хязгаар лалтаас Чөлөөл сөн автотээврийн хэрэгслийн тоо	10	5	Тайлангийн хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээний том болон бага оврын автобус, таксийн үйлчилгээний, ажилчид тээвэрлэх, хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийг шалгаж улсын байцаагчийн дүгнэлт гаргаж, бүртгэлийн санд бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагууд "admin.ptd.ub.gov.mn" программаар хандсаныг хүлээн авч "Аз хулан" ХХК, "Юбикабо бригада хороош", "ЭМ СИ ЭС интершинол" ХХК-ийн тээврийн хэрэгслүүдэд дүгнэлт гарган баталгаажуулж ажилласан.	01-12	100
5.2	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгөх, өргөдөл, гомдлын хугацаанд нь барагдуулж, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Өргөдөл гомдлын хугацааг бууруулж, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах хувь	184	263	Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 1111 төвд иргэдээс ирүүлсэн 358 өргөдөл, гомдлыг, тус байгууллагын иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах 70047004 утсаар иргэдээс ирүүлсэн 89, Нийтийн тээвэр-Public transport UB цахим хаягаар ирсэн 9, нийт 263 санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч 100 хувь барагдуулж ажилласан. Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны иргэдээс иргүүлсэн гомдол, саналыг хэлтсийн даргад танилцуулж, газар дээр нь хяналт шалгалтыг явуулж зөрчил гаргасан 3 аж ахуйн нэгжийн 5 жолоочид торгох шийтгэл оногдуулж дахин зөрчил гаргахгүй ажиллах үүрэг өгсөн.	01-12	100
Зорилт 6. Хэлтсийн чиг үүргийн хүрээнд							
6.1	Нийслэлийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын шаардлагад хяналт тавих, энэ чиглэлээр тээвэрлэгч аж ахуй нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн хувьд зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн	Хийгдсэн арга хэмжээний тоо	10	3	Тайлангийн хугацаанд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгслийн жолооч нарыг Автотээврийн тухай хууль, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг хэрхэн хангаж үйлчилгээнд ажиллаж байгаад хяналт шалгалт хийж, 104 жолоочийн гаргасан дутагдал мэргэжил гар зүйн зөвөлгөө өгч, зөрчлийн 37 холбогдогчид Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 хэсгийн 1.1 дэх заатыг үндэслэн 1450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж ажилласан.	01-12	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	зөрчилд хариуцлага тооцож ажиллана;						
6.2	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;	Хяналт шалгалтын тоо	10	4	Удирдлагаас өгсөн үүргийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй ажилладаг Мяралзаа ХХК, Трансбус ХХК, Үнэгтийн-Уул ХХК, ЭМСИД ХХК, ДЮЦ ХХК-ууд үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслүүдэд хийгдэж буй угаалга, цэвэрлэгээний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Зөрчилтэй аж ахуйн нэгжүүдэд албан мэдэгдэл хүргүүлж ажилласан.	01-12	100
